

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ №-1

УРГИЙН ОВОГ: ХАРДАЛ

ОВОГ: БАДАРЧ

НЭР: ДАВААЖАВ

НАС: 69

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: ХЭРЛЭН СУМ



Бадарч овогтой Даваажав нь соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, морин хуур, хуучир хөгжмийн нэрт багш, уран бүтээлч юм. Тэрээр 1956 онд Хэнтий аймгийн Баянхутаг суманд төрж, 7 настайгаасаа эцэг Бадарчаасаа морин хуур, хуучир хөгжмийг суралцан өвлөж авсан. Одоогоор Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р багт амьдарч байна.

1970-аад оноос эхлэн соёлын биет бус өвийг сурталчлан түгээн дэлгэрүүлэх, шавь сургах үйлсэд тасралтгүй хүчин зүтгэж, аймаг, сум, байгууллагын хэмжээнд хөгжмийн сургалт, уран бүтээлийн ажлыг өргөн хүрээнд хийж ирсэн. Тэрээр Цэргийн дуу бүжгийн чуулгад морин хуурчаар ажиллаж, Хэнтий болон Сүхбаатар аймгийн олон сумдад хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд морин хуур, хуучир хөгжмийг заан сургаж байв.

2005 оноос “Сэцэн Монгол” морин хуурын дугуйланг тасралтгүй ажиллуулж, өнөөдөр чуулгын дэргэд 30 гаруй хүүхдэд морин хуурыг өвлүүлэн сургаж байна. Нийтдээ 14,000 гаруй шавь бэлтгэснээс олонх нь Соёл урлагийн их сургууль, МУ-ын Консерваторыг төгсөн мэргэжлийн хөгжимчин, багш, уран бүтээлчээр амжилттай ажиллаж байна.

Түүний шавь нараас МУСТА цолтон, улсын болон олон улсын уралдаан, фестивалийн гранпри, медальтнууд олноор төрөн гарч, “Ая эгшгийн зургаан жигүүр”, олон улсын хөгжмийн тэмцээнүүдэд тогтмол амжилт үзүүлсээр ирсэн. 2025 онд “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалиас “Шавь сургалтын шилдэг туршлагатай өвлөн уламжлагч” шагнал хүртсэн нь түүний хөдөлмөрийн бодит үнэлгээ юм.

Мөн тэрээр дуу, бүжиг, үндэсний хөгжимд зориулсан уран бүтээлүүд туурвиж, морин хуур, найрал хөгжимд зориулсан аялгуу, оркестровк бүхий олон бүтээл туурвисан туршлагатай уран бүтээлч юм.

Олон жилийн хөдөлмөр, соёлын өвийг хамгаалж хөгжүүлсэн гавьяаг нь үнэлж Хөдөлмөрийн хүндэт медаль, Соёлын тэргүүний ажилтан, “Алтан гадас” одон зэрэг төрийн дээд шагналуудаар шагнагдсан.

УРГИЙН ОВОГ-

ОВОГ: ДУГАРСҮРЭН

НЭР: НЯМБУУН-ЯДМАА

НАС: 60

ХҮЙС: ЭМЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: АРХАНГАЙ ӨНДӨР-УЛААН СУМ



Д.Нямбуунядмаа нь 1965 онд Архангай аймгийн Өндөр-Улаан суманд төрсөн, 60 настай. Тэрээр соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч бөгөөд уламжлалт арга ухааны ай савд хамаарах цагаан идээ бэлтгэх уламжлалт арга болон мал маллах, ялангуяа сарлаг маллах арга ухааны өвийг аав, ээжээсээ өвлөн уламжилж авсан.

2001 онд сумын аварга шалгаруулах “Амтат идээ” үзэсгэлэнд дэд байр эзэлснээс хойш өнөөг хүртэл сум, аймаг, улсын чанартай үзэсгэлэн, уралдаан, арга хэмжээнд тогтмол амжилттай оролцож, олон удаагийн шагналт байранд шалгарч ирсэн. Тэрээр уламжлалт мал аж ахуй, цагаан идээ бэлтгэх арга ухааныг улсын болон олон улсын хэмжээнд сурталчлан таниулж байна.

Түүний хөдөлмөр, ур чадварыг үнэлж дараах төрийн болон салбарын шагналуудыг хүртээсэн байна. Үүнд:

Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн тэргүүний ажилтан (2012)

МЭХ-ны “Манлай малчин эмэгтэй” хүндэт тэмдэг (2017)

Худалдаа, үйлчилгээний тэргүүний ажилтан (2017)

Улсын аварга саальчин (2019)

Өндөр-Улаан сумын Хүндэт иргэн (2023)

“Алтан гадас” одон (2024)

Мөн тэрээр “Архангай Түншлэл”, “Цагаан сар” цагаан идээний үзэсгэлэнгүүдэд олон жил дараалан амжилттай оролцож, ширгээмэл ааруул, тавгийн идээ төрлөөр шилдэг нэрийн бүтээгдэхүүн, шилдэг брэнд, тэргүүн болон шагналт байр эзэлж байв.

Д.Нямбуунядмаа нь 2022 онд Франц улсад сарлаг маллах арга ухаан, цагаан идээ бэлтгэх уламжлалт аргыг сурталчлах арга хэмжээнд оролцсон. Үүний үр дүнд 2025 оны 7 сард Францын иргэд Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Азарга багийн Шаргачин хэмээх газарт оршин суудаг түүнийд зочилж, сарлаг маллах болон цагаан идээ бэлтгэх уламжлалт арга ухаантай биечлэн танилцсан байна.

Түүнчлэн Соёлын бүтээлч сар аяны хүрээнд 3 жил дараалан Улсын аварга саальчин, өвлөн уламжлагч Д.Нямбуунядмаагийн нэрэмжит “Аварга саальчны цагаан идээ” үзэсгэлэнг зохион байгуулж, цагаан идээ бэлтгэх уламжлалт аргын талаар шавь сургалт тогтмол зохион байгуулж ирсэн.

### ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ №-3

УРГИЙН ОВОГ: ДУУТАН

ОВОГ: ЖАДАМБА

НЭР: ЭРХЭМСАЙХАН

НАС: 61

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: ДУНДГОВЬ ЛУУС СУМ

Дуутан овогт Жадамбаагийн Эрхэмсайхан нь 1964



оны 11 дүгээр сарын 26-нд Дундговь аймгийн Луус суманд төрсөн. Монгол хэл, уран зохиолын багш мэргэжилтэй, хэл шинжлэлийн ухааны магистр, тэргүүлэх зэрэгтэй багш юм.

Тэрээр боловсролын салбарт 40 орчим жил үр бүтээлтэй ажиллахдаа үндэсний Монгол бичгийг сурч, судлах, түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт тууштай зүтгэж, өсвөр үе, сурагч багачуудад үндэсний хэл бичиг, утга соёлын үнэт өвийг системтэйгээр заан сургаж ирсэн. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монголчуудын бичиг үсэг, бичгийн соёлд хамаарах соёлын биет бус өвийг судлах, өвлөн уламжлуулах чиглэлд оюун ухаан, мэдлэг чадвар, авьяас билгээ бүрэн дайчлан ажиллаж буй шилдэг өвлөн уламжлагч юм.

Түүний олон жилийн уйгагүй хөдөлмөр, мэргэжлийн ур чадвар, соёлын өвийг хамгаалан хөгжүүлэх үйлсийг өндрөөр үнэлж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас зохион байгуулсан “НҮҮДЭЛЧИН” дэлхийн соёлын фестиваль наадмуудад 2022, 2023, 2024, 2025 онуудад дараалан амжилттай оролцож, уг наадмын хүрээнд хоёр удаа “Шилдэг өвлөн уламжлагч” цол, шагналаар шалгарсан байна.

Ж.Эрхэмсайхан нь үндэсний Монгол бичиг, хэл соёлын биет бус өвийг хойч үед өвлүүлэн уламжлуулах, олон нийтэд сурталчлан таниулах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж буй, эрдэм мэдлэг, туршлага хосолсон нэр хүндтэй өвлөн уламжлагч билээ.

2022 онд “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” төрөлд Үндэсний бичгийг уран зураг, уран баримал, уран хайчилбар, уран дархан зэрэг гар урлалын бусад төрлүүдтэй холбон хийсэн бүтэлүүдээрээ “ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ”, “НҮҮДЭЛЧИН” дэлхийн соёлын фестиваль наадамд, 2025 онд “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” болон нэн яаралтай хамгаалах өвийн жагсаалтад бүртгэгдсэн “Монголчуудын ном бүтээж ирсэн өв уламжлал” төрөлд уламжлалт нагтан зургийн аргаар бүтээсэн эвхмэл болон хуйлмал судруудаараа “ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ”-аар шалгарсан. Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 2024 оны 5 дугаар сард Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд зохион байгуулсан “МОНГОЛ ГЭР” соёл урлагийн үзэсгэлэн арга хэмжээнд оролцож,

Монголчуудын хэл бичиг соёлыг өөрийн орны ард иргэд болон гадаадын аялагч жуулчдад сонирхуулж сурталчилсан байна.

2025 оны 11 дүгээр сарын 19-өөс 12 дугаар сарын 3-нд “ДЭЛХИЙН МӨРӨӨДЛИЙН СУРГУУЛЬ” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай хамтран “НҮҮДЛИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ” хөтөлбөрийн хүрээнд дэлхийд тархан суурьшсан монголчуудад эх хэл, соёл уламжлалыг таниулан сурталчлах, өвлүүлэн уламжлуулах зорилгоор Франц, ХБНГУ, Бельги зэрэг европын орнуудад зохион байгуулсан үзэсгэлэнд монголчуудын ном судар бүтээж ирсэн өв уламжлалыг шингээн бүтээсэн эвхмэл болон хуйлмал судруудыг дэлгэн сонирхуулж, цаашид энэ чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр ажиллаж байна.

Өөрийн санаачилгаар соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад зохион байгуулсан арга хэмжээ: Тэрээр 2007 оноос хойш төв орон нутгийн боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагууд болон төрийн бус байгууллагуудтай хамтран ҮНДЭСНИЙ МОНГОЛ БИЧИГ-ийн үзэсгэлэнг тогтмол зохион байгуулж ирсэн байна.

Үүнд: Монгол улсын Үндэсний номын сан (2008), Дархан-Уул аймгийн ЗДТГ (2016), Боловсрол соёлын газар (2015, 2022, 2023), Төв номын сан (2010), Хүүхдийн номын ордон (2007), Музей (2008), ХААИС (2016), “Залуучууд” театр (2016, 2024) “Залуучуудын хөгжлийн төв” (2023) зэрэг газруудад өөрийн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, үндэсний бичиг соёлоо түгээжээ.

УРГИЙН ОВОГ:

ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ №-4

ОВОГ: БЯМБАЦОГТ

НЭР: МӨНХТУЯА

НАС: 39

ХҮЙС: ЭМЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: ХОВД АЙМАГ, ДУУТ СУМ



Бямбацогт овогтой Мөнхтуяа нь 1987 онд Ховд аймгийн Дуут суманд төрсөн. 1994–2004 онд Ховд аймгийн 3 дугаар 10 жилийн сургуулийг төгсөж, 2004–2008 онд Завхан аймаг дахь Монгол Улсын Их сургуулийн салбар сургуулийг банкны эдийн засагч Нягтлан бодогч мэргэжлээр төгссөн.

2008-2017 онд байгууллагын удирдлага, банк, барилгын салбарт ажилласан бөгөөд 2017 оноос гар урлалын чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхэлж, соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах үйлсэд тууштай оролцож байна.

Өвлөн уламжлагч Б.Мөнхтуяа нь хүүхэд ахуй наснаасаа мал маллах, малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, зүү ороох уран хатгамал, зээгт наамал, зоосон ширээний сүлжмэл, дээс томох, ширдэг ширэх зэрэг уламжлалт гар урлалыг эмээ, ээж нараасаа өвлөн суралцсан. Бага наснаасаа гарын ур дүйтэй, сонирхолтой байсан нь түүнийг уран хатгамалч болгон төлөвших суурь болсон.

2013 оноос хойш зүү ороох хатгамал, зээгт наамал, зоосон ширээний сүлжмэлийн урлалыг мэргэжлийн түвшинд тууштай хөгжүүлж, улсын болон олон улсын чанартай уралдаан, үзэсгэлэнд тогтмол амжилттай оролцож ирсэн. Тухайлбал:

Монгол, Хятадын экспо (2023),

“Гайхамшигт өв соёл – Монгол уран хатгамал” уралдаан (2023),

“АРТФИЛ”, “Монголын сайхан орон” үзэсгэлэн,

“Дээлтэй Монгол” наадам,

“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль (2021–2025) зэрэг арга хэмжээнд

Завхан аймаг, Урианхай угсаатны онцлогийг харуулсан бүтээлээрээ оролцсон.

Тэрээр 2018–2025 онуудад зүү ороох, оёдол хатгамлын төрлөөр улс, аймгийн тэргүүн байр, шилдэг бизнес эмэгтэй, шилдэг өрхийн үйлдвэрлэгч, шилдэг өвлөн уламжлагч, онцлох бүтээлч залуу зэрэг олон шагнал, хүндэтгэлийг хүртсэн. Мөн Монголын үндэсний уламжлалт уран хатгамалчдын өвлөн уламжлагч хатгамалч тэмдгээр шагнагдсан.

Мэргэжлээ тасралтгүй дээшлүүлж, мэргэжлийн сургалт, ахисан шатны дамжаанд хамрагдан, музейн үзмэр, эрдэм шинжилгээний эх сурвалжид тулгуурлан Завхан аймгийн онцлогийг шингээсэн судалгаатай бүтээл туурвихыг зорьж байна.

Өдгөө 2000 орчим шавьтай, тэднээс 100 гаруй нь байнгын сургалтад хамрагдаж, танхим болон онлайнаар зүү ороох, зоосон ширээний сүлжмэлийн сургалтыг тогтмол явуулж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд соёл, урлагийн бүтээл, арга хэмжээг өөрийн урлалаар дэмжин ажилладаг. 3 дахь үеийн өвлөн уламжлагч Б.Мөнхтуяа нь соёлын биет бус өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж, хойч үед өвлүүлэн уламжлуулахад бодитой хувь нэмэр оруулж буй шилдэг уран хатгамалч, өвлөн уламжлагч юм.

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ №-5

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ЭЖЭЭ

НЭР: ТОЙВГОО

НАС: 68

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УВС АЙМАГ ЗҮҮН-ГОВЬ

СУМ



Эжээ овогтой Тойвгоо Монгол Улсын Гавьяат жүжигчин, хөөмийчин

Эжээ овогтой Тойвгоо нь 1957 онд Увс аймгийн Зүүнговь суманд төрсөн. Бага насаа малчин ахуйд өнгөрүүлж, малын бэлчээрт явж байхдаа магнетфоноор хөөмий сонсож, даган дууриаснаар хөөмийн битүү амьсгааны урлагийг бие даан эзэмшсэн юм.

1980 онд Бүх ард түмний урлагийн их наадамд хөөмийн төрлөөр шалгарснаар Увс аймгийн Хөгжимт драмын театрт уригдан, улмаар 28 жил тасралтгүй хөөмийчнөөр ажилласан. Театрт ажиллах хугацаандаа Монгол ардын 20 гаруй дууг хөөмийлж, өөрийн үг, аятай “Буурал тохой нутаг” магтаалыг олны хүртээл болгож, “Алтай хайрхан” нэртэй (CD) гаргасан.

Тэрээр “Ханхөхийн цуурай”, “Говь Хангайн цуурайн эгшиглэн”, “Хөөмийн цуурай”, “Увсын цэнхэр хязгаар” зэрэг бие даасан томоохон тоглолтуудыг зохион байгуулж, Монгол Улсын 3 хот, 21 аймаг, 300 гаруй суманд 1500 гаруй удаагийн тоглолт хийж, 500,000 гаруй үзэгчдэд язгуур хөөмийн урлагийг хүргэсэн.

Э.Тойвгоо нь Монголын хөөмийг дэлхийд сурталчлан таниулах үйлст онцгой хувь нэмэр оруулж, 20 гаруй улс оронд аялан тоглолт хийсэн. Түүний авьяас чадварыг өндрөөр үнэлж:

1987 онд БНСВУ-д “Хо Ши Мин хотын Хүндэт иргэн”, “Соёлын тэргүүн”,

1991 онд Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан,

2001 онд Монголын хөөмийн холбооноос “Алдарт хөөмийчин”, “Хөөмийн амьсгааны хаан”,

2001 онд Монгол Улсын Гавьяат жүжигчин цолоор тус тус шагнасан.

Тэрээр хөөмийн үндсэн дуугаралтыг хархираа, харгиа хөөмийгөөр баяжуулж, битүү амьсгаагаар монгол ардын дууг олон бадаг хөөмийлдгөөрөө хөөмий судлаачдын өндөр үнэлгээг хүртсэн.

2000 оноос хойш шавь сургалт явуулж, Увс аймгийн 12 сумын 200 гаруй хүүхэд, нийтдээ 640 гаруй хөөмийчнийг бэлтгэн гаргасан. Түүний шавь нараас улсын болон

олон улсын уралдаанд тэргүүн байр, гранпри, алтан медальтнууд төрөн гарсан нь түүний өвлүүлэн уламжлуулах ажлын бодит үр дүн юм.

Э.Тойвгоо нь 2010 онд ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад “Монголын уламжлалт хөөмийн урлаг”-ийг бүртгүүлэхэд дуу, дүрсний баримт, судалгааны мэдээллээр оролцож, хөөмийг Монголын өв болохыг баталгаажуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн.

Түүний язгуур хөөмийн урлагийг өвлөн хадгалж, дэлхий дахинд сурталчлан түгээн дэлгэрүүлж, хойч үедээ өвлүүлэн уламжлуулсан онцгой гавьяа зүтгэлийг үнэлж, 2012 онд “Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн Монголын Билэг авьяастнуудын Улсын жагсаалт”-д, мөн 2019 онд батлагдсан Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн Үндэсний жагсаалт-д бүртгэсэн байна.

Иймд Монгол Улсын Гавьяат жүжигчин, хөөмийчин Эжээ овогтой Тойвгоо агсан нь Монголын уламжлалт хөөмийн урлагийг өвлөн хадгалж, дэлхий дахинд сурталчлан алдаршуулж, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан шилдэг өвлөн уламжлагч болно.

- ✓ Монголын бүх ард түмний урлагийн үзлэгийн тэргүүн байр – 1980
- ✓ ОХУ-ын Тува Улсын Кызыл хотод болсон Ардын урлагийн наадмын шилдэг үзүүлбэрийн тэргүүн байр – 1981
- ✓ Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хо Ши Мин хотын “Хүндэт иргэн”, “Соёлын тэргүүн” цол, тэмдэг – 1987
- ✓ БНАСАУ-ын “Хаврын баяр” урлагийн наадмын алтан медаль – 1989
- ✓ Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан” цол, тэмдэг – 1991
- ✓ ОХУ-ын Тува Улсын Кызыл хотод болсон олон улсын хөөмийчдийн уралдааны тэргүүн байр – 1992
- ✓ Монголын Хөөмийн холбооноос олгосон Баруун Монголын “Алдарт хөөмийчин”, хөөмийн “Амьсгааны хаан” чимэг – 2000
- ✓ Монгол Улсын 3 хот, 21 аймаг, 300 гаруй суманд 1500 гаруй удаагийн тоглолт хийж, 500 000 гаруй үзэгчдэд хүрсэн – 1981–2008
- ✓ ХБНСЮУ, БНСУ, БНАСАУ, БНСВУ, БНАААУ, БНАЛАУ, Камбожийн Хаант Улс, Япон Улс, ОХУ, Франц Улс, ХБНГУ зэрэг 20 гаруй оронд аялан тоглолт хийсэн – 1981–2008
- ✓ Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртсэн – 2001
- ✓ Монгол Улсын “Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн Монголын билэг авьяастнуудын улсын жагсаалт”-д бүртгэгдсэн – 2012
- ✓ Засгийн газрын 475 дугаар тогтоолоор соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг шинэчлэн баталсан – 2019

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ОХИН

НЭР: ЛХАГВААЖИЙ

НАС: 80

ХҮЙС: ЭМЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: ХӨВСГӨЛ, БАЯНЗҮРХ СУМ

Охин овогтой Лхагваажий Бүжигчин, язгуур урлагийн өвлөн уламжлагч



Охин овогтой Лхагваажий нь 1945 онд Хөвсгөл аймгийн Баянзүрх суманд төрсөн. Бага наснаасаа малчин ахуйд өсөж, 1954 онд сумын бага сургуулийн 4 дүгээр ангийг төгссөн. 1960 оноос эхлэн сумын уран сайхны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, 1961 онд Ардын хувьсгалын 40 жил, аймгийн 30 жилийн ойн нэгдсэн тоглолтод оролцсоноор уран бүтээлийн гараагаа эхлүүлсэн.

1961 оны 11 дүгээр сард 16 настайдаа Аймгийн Соёлын ордонд бүжигчнээр ажилд орж, УГЖ Лувсангомбо, Н.Базаржав нарын удирдлага дор мэргэжлийн бүжигчин, жүжигчний замналаа эхлүүлсэн. Улмаар Соёлын ордноос Хөгжимт драмын театр болтлоо 30 гаруй жил тасралтгүй ажиллаж, Монгол ардын болон орчин үеийн 50 гаруй бүжиг, олон драмын жүжгийн гол болон туслах дүрийг амжилттай бүтээсэн.

Тэрээр бүжгийн ангийн ахлагчаар 20 гаруй жил ажиллаж, хамт олноо мэргэжлийн ур чадвар, сахилга зохион байгуулалтаар манлайлан удирдаж, улсын чанартай уралдаан, наадмаас удаа дараа тэргүүн байр эзлүүлсэн. Мөн Монгол Улсын 18 аймаг, сумдын 60 гаруй хувьд урлагийн бригадын тоглолт хийж, орон нутгийн иргэдэд соёл, урлагийг тогтмол хүргэсэн.

1991 онд тэтгэвэрт гарснаас хойш уран бүтээл, сургалтын ажлаа орхилгүй, цэцэрлэг, сургууль, сум, байгууллагуудад бүжиг зааж сурган, 600–700 гаруй хүнд бүжгийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлсэн. Залуу уран бүтээлчдийг дэмжин, залгамж халааг бэлтгэхэд онцгой хувь нэмэр оруулсан.

Мөн 1995 оноос эхлэн ардын язгуур урлагийн хоолойн лимбэ, хэл хуурын урлагийг бие даан эзэмшиж, өвлөн уламжлагчийн хувиар идэвхтэй түгээн дэлгэрүүлсэн. Ардын урлагийн их наадамд удаа дараа амжилттай оролцож, алт, мөнгөн шагнал хүртсэн. Хоолойн лимбээр 6 шавь бэлтгэн сургасан бөгөөд тэд цаашид өвлөн уламжлуулах үйлсэд оролцож байна.

Гадаад, дотоодын олон тоглолт, наадам, фестивальд оролцож, Хөвсгөл аймгийн язгуур урлагийг сурталчлан таниулсан. Тухайлбал, БНХАУ-д зохион

байгуулагдсан олон улсын ахмад настны фестивалиас тэргүүн зэргийн хүрэл цом хүртсэн.

Гавьяа, шагнал

Монголын залуучууд, оюутны III наадмын хүрэл медаль (1968)

Хөдөлмөрийн хүндэт медаль (1971)

Алдарт эхийн II одон (1972)

Алтан гадас одон (1981)

Соёлын тэргүүний ажилтан (1986)

Ардын хувьсгалын 60, 70, 80, 90, 100 жилийн ойн медалиуд

О.Лхагваажий нь соёл, урлагийн салбарт 61 жил тасралтгүй ажиллаж, бүжиг, язгуур урлагийн үнэт өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж, хойч үед өвлүүлэн уламжлуулж буй ховорхон туршлагатай, нэр хүндтэй өвлөн уламжлагч тул соёлын биет бус өвийг үндэсний болон олон улсын хэмжээнд сурталчлан таниулсан өвлөн уламжлагчаар үнэлэх бүрэн үндэслэлтэй юм.

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ №-7

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ЦЭРЭН

НЭР: БАТЦЭРЭН

НАС: 59

ХҮЙС: ЭМЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: БУЛГАН АЙМАГ, САЙХАН СУМ



Ц.Батсүрэн нь 1966 онд Булган аймгийн Сайхан суманд 10 хүүхэдтэй айлын зургаа дахь охин болон төрсөн. Тэрээр Монгол бөхийн зодог, шуудаг, малгай, гутал урлах уламжлалт гар урлалыг ааваасаа өвлөн авсан хоёр дахь үеийн өвлөн уламжлагч бөгөөд 1983 оноос хойш 32 жил тасралтгүй өвлөн уламжилж байна.

Түүний аав Даян аварга Сэрээтэрийн Цэрэн нь Монгол бөхийн 33 шинжийн 32 нь бүрдсэн нэртэй бөх бөгөөд тухайн цаг үедээ бөхчүүдийн зодог, шуудаг урлан хийдэг байсан. Ээж нь үндэсний дээл, малгай оёдог байсан нь гэр бүлийн бүх хүүхдэд өвлөгдөн үлдсэн. Төрсөн эгч Ц.Даваасүрэн нь одоо Монгол бөхийн өргөөнд жанжин малгай урладаг. Ийнхүү бөхийн удам, гар урлалын уламжлалыг хадгалсан гэр бүлээс төрсөн Ц.Батсүрэн нь өнөөдөр Монгол бөхийн эдлэл хэрэгслийг иж бүрнээр нь урлан түгээн дэлгэрүүлж буй ховор өвлөн уламжлагч юм.

Амжилт, уралдаан тэмцээнд оролцсон байдал:

2025 онд “Монгол гутлын үйлдвэр”-ийн 50 жилийн ойн медалиар шагнагдаж, мөн “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд монгол бөхийн зодог, шуудагны иж бүрдэл бүтээлээр оролцон Бүтээлч үйлдвэрлэлийн төрөлд “Шилдэг өвлөн уламжлагч”-аар шалгарч, 1 сая төгрөгийн урамшуулал хүртсэн.

Тэрээр “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль, Сайхан суманд зохион байгуулагддаг “Алтан намар”, “Монгол дээл”, “Гоёл чимэглэл” зэрэг үзэсгэлэн, худалдаанд тогтмол оролцож, өөрийн урласан бүтээлийг олон нийтэд сурталчлан түгээн дэлгэрүүлсээр байна.

Бүтээл, үйлдвэрлэл

Өдгөө үндэсний бөх, хурдан морины уяач, сур харваачдад зориулан:

Монгол малгай – 120 ширхэг

Хүүхдийн зодог, шуудаг (3–10 нас) – 320 ширхэг

Өсвөр насныханд – 300 ширхэг

Насанд хүрэгчдэд – 200 гаруй зодог, шуудаг

Монгол гутал – 170 ширхэг

нийт 1100 гаруй бүтээл урлан хэрэглэгчдэд хүргэсэн байна.

Түүний урласан зодог, шуудаг, малгай, гутлыг улс, аймгийн алдар цолтой олон бөх, харваачид хэрэглэж ирсэн бөгөөд тэдгээрээс Булган аймгийн хурц арслан

Ө.Сүхбат, Улсын начин Оргилболд, Улсын хошой мэргэн Ө.Эрдэнэбат, аймгийн заан Д.Мягмардорж зэрэг нэрт тамирчдыг дурдаж болно.

Өв хамгаалал, шавь сургалт:

Ц.Батсүрэн нь өөрийн охид болох А.Ариунаа, Т.Батцэцэг, Т.Эрдэнэчимэг нарт бага наснаас нь Монгол бөхийн зодог, шуудаг урлах ухааныг өвлүүлэн сургасан. Мөн 2017 оноос хойш Булган, Сайхан сумын иргэдэд шавь сургалтаар уг урлалыг зааж, өвлөн уламжлуулж байна.

Түүний охин А.Ариунаагийн урласан зодог, шуудаг, жанжин малгай нь 2014 онд “Сумын шилдэг брэнд бүтээгдэхүүн”-ээр шалгарсан нь гэр бүлийн уламжлал амжилттай үргэлжилж буйн илрэл юм.

Ц.Батсүрэн нь Монгол бөхийн эдлэл хэрэгслийн уламжлалт урлалыг хадгалан хамгаалж, үйлдвэрлэл, сургалт, сурталчилгааг хослуулан хөгжүүлж буй, соёлын биет бус өвийг бодитоор түгээн дэлгэрүүлж буй манай улсын нэр хүндтэй өвлөн уламжлагч билээ.

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ-8

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ДАГВА

НЭР: ДАРЖАА

НАС: 58

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: БАЯНХОНГОР, БАЯННОВЬ  
СУМ



Давга овогтой Даржаа нь 1967 онд Баянхонгор аймгийн Баянговь суманд Давгын гурав дахь хүү болон төрсөн. Одоо эхнэрийн хамт Баянговь сумын Цоохор 4 дүгээр багт уламжлалт мал аж ахуй эрхлэн амьдарч байна. 1974 онд Баянговь сумын 8 жилийн сургуульд элсэн орж, 1983 онд төгссөн бүрэн бус дунд боловсролтой. 3 дахь үеийн өвлөн уламжлагч.

Д.Даржаа нь соёлын биет бус өвийн нэгэн төрөл болох хулсан болон аман хуур хөгжмийг буурал ээж Дуламаасаа өвлөн сурсан. Өдгөө хулсан хуур, нуман хуур, гуйлан хуур, төмөр хуур зэрэг хөгжмийг чадварлаг тоглодог бөгөөд хулс, үхэр болон ямааны эвэр ашиглан 120 гаруй хөгжим урлан бүтээж, Монголын Хэл хуурын холбоо болон хөгжим тоглох сонирхолтой хүүхэд, залууст хандивласан байна.

Тэрээр хуур тоглохоос гадна исгэрээ, дуулах авьяастай бөгөөд 2023 онд Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “1000 малчдын урлаг, спортын наадам”-д тагнайн исгэрээ төрөлд оролцож тусгай байр эзэлсэн нь энэхүү ховордсон язгуур урлагийг өвлөн хадгалж буйн тод илрэл юм.

Оролцоо, амжилт:

2024 он – “Нүүдэлчдийн хэмнэл – Хэл хуур мину” үндэсний анхдугаар наадмаас тусгай байр,

2024 он – Монгол угсаатан хэл хуурчдын холбооны анхдугаар чуулганд уригдан оролцов.

2024 он – Ардын хувьсгалын 103 жилийн ойн Үндэсний их баяр наадмын нээлтэд уламжлалт хэл хуурын тоглолтоор оролцов.

2024 он – Баянговь сумын “Оны шилдэг өвлөн уламжлагч”

2025, 2025 оны – “Нүүдэлчин” фестивальд оролцсон.

Япон улс, Токио хот – Хэл хуурчдын дэлхийн 10 дугаар фестивальд Монгол Улсаа төлөөлөн оролцож, хулсан хуурыг сурталчилан таниулсан. Монгол угсаатан хэл хуурчдын холбоо байгуулагдсантай холбогдуулан гишүүнээр элсэж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Сургалт, өв хамгаалал:

Монгол Улсын хэмжээнд 3 аймагт байгуулагдсан Хэл хуурын тэнхимийн нэг болох Баянхонгор аймгийн Баянговь сумын Соёлын төвийн дэргэдэх Хэл хуурын тэнхимийн сургагч багш-аар ажиллаж, одоогоор 25 хүүхэд, 9 насанд хүрэгчдэд хэл хуурын сургалтыг амжилттай зохион байгуулж байна.

Тэрээр 1978 оноос эхлэн хулсан хуур хөгжмийн өвийг буурал ээж Р.Дуламаа, өөрийн ээж Лхагва нараас өвлөн сурч, хулсан хуур хийх арга ухаан, тоглох уламжлалт аргыг эзэмшиж эхэлсэн. Улмаар 2010 оноос эхлэн хулсан хуураа өөрөө урлан хийж, бие даан тоглож сурсан бөгөөд өдгөө уг өвийг түгээн дэлгэрүүлэгч, сургагч багшаар идэвхтэй ажиллаж байна.

2024 онд: Хэл хуур тоглогчдын үндэсний уралдаан “Нүүдэлчдийн хэмнэл – Хэл хуур мину” анхдугаар наадмаас тусгай байр хүртсэн

Монгол угсаатан хэл хуурчдын холбооны анхдугаар чуулганд урилгаар оролцсон

Ардын хувьсгалын 103 жилийн ойн Үндэсний их баяр наадмын нээлтэд “Монгол уламжлалт хэл хуурын тоглолт”-оор оролцсон Монгол угсаатан хэл хуурчдын холбоо байгуулагдсантай холбогдуулан гишүүнээр элссэн “Оны шилдэг авьяастан” цолоор шалгарсан.

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ №-9

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: РАШДЭЛЭГ

НЭР: ЦЭРЭНДЭГД

НАС: 83

ХҮЙС: ЭМЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: ӨВӨРХАНГАЙ,  
НАРИЙНТЭЭЛ



Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Сайн ноён хан аймгийн Хөнхөгшин хошууны Шаргын уртын дууны язгуур өвийн өвлөн уламжлагч, уртын дуучин, хоолойн лимбэчин, хэл хуурч, цуурын ятгачин, хөгжимчин Рашдэлэгийн Цэрэндэгд нь Монголын язгуур урлагийг олон төрөл зүйлээр нь цогцоор нь өндөр түвшинд өвлөн уламжилж, түгээн дэлгэрүүлсэн нэрт өвлөн уламжлагч юм.

Тэрээр 10 наснаасаа эхлэн Нарийнтээл суманд уламжлагдан дуулдаг “Улаан торгон дээл”, “Нарийн хөх бор”, “Газрын холоос”, “Жаахан бор”, “Саруул тал”, “Төгрөг нуур”, “Шар талын цэцэг”, “Өлийн сувдан хар” зэрэг олон ардын уртын дууг өвлөн сурч, уран бүтээлийн замналаа эхлүүлсэн. 1983 онд зохион байгуулагдсан Ардын язгуур урлагийн Их наадмаас мөнгөн медаль хүртэж байв.

“Хоолойн лимбэ”-ийг нагац ах Ц.Нацагдорж болон нэрт лимбэчин Ц.Цэрэннадмид нараас сонсож, өөрийн уйгагүй хөдөлмөрөөр 70 гарсан хойноо эзэмшин, улмаар энэхүү ховордсон язгуур өвийг өндөр түвшинд хөгжүүлж, 2025 онд Дэлхийн соёлын фестиваль “Нүүдэлчин–2025” наадмаас “Хоолойн лимбэ” төрлөөр “Шилдэг өвлөн уламжлагч” шагналыг хүртсэн.

Мөн “Цуурын ятга” хөгжмийг 1983 онд өвлөн уламжлагчдаас суралцаж, баримтат кинонд тоглон оролцож, Нарийнтээл сумын онцлог болсон энэхүү хөгжмийн дэг сургуулийг өнөөг хүртэл уламжилж байна. Соёл судлалын ухааны доктор А.Алимаа түүнийг халхын нэртэй уртын дуучин, цуурын ятгын дэг сургуулийг хадгалж яваа өвлөн уламжлагч хэмээн үнэлсэн байдаг.

Р.Цэрэндэгд нь соёл, урлагийн салбарт 63 жил тасралтгүй ажиллаж, давхардсан тоогоор 8 сая гаруй хүнд язгуур урлагийг сурталчлан таниулж, 6878 тоглолтод оролцон, сум, аймаг, улс, олон улсын түвшинд 150 гаруй шагнал хүртсэн манай аймгийн бахархал болсон уран бүтээлч юм.

Тэрээр ардын уртын дуу, хэл хуур, хоолойн лимбэ, цуур ятга зэрэг язгуур өвийг 1500 гаруй хүүхэд, залуучуудад заан сургаж, 500 гаруй шавьтай болжээ. Түүний шавь

нараас Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан, олон улсын уралдааны шагналтнууд төрөн гарсан байна.

2018 оноос эхлэн Нарийнтээл суманд хоёр жил тутам өөрийн нэрэмжит “Шаргын шуранхай” уртын дууны уралдааныг зохион байгуулж, “Удам залгасан уртын дууч” дурсамжийн номоо хэвлүүлэн, язгуур өвөө хойч үедээ үлдээсэн.

Ийнхүү Рашдэлэгийн Цэрэндэгд нь Монголын биет бус соёлын өвийн “Язгуур урлагийн төрөл”-ийг цогцоор нь өндөр түвшинд өвлөн уламжилж, сум, аймаг, бүс нутаг, олон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн үндэсний хэмжээний шилдэг өвлөн уламжлагч юм.

Шагнал, цол хүндэтгэлийн товч жагсаалт:

1983 он – Ардын язгуур урлагийн Их наадам, *Мөнгөн медаль*

1988 он – Ардын язгуур урлагийн Улсын II үзлэг, *Мөнгөн медаль*

1991 он – Ардын хувьсгалын 70 жилийн ойн медаль

1991 он – С.Гончигийн нэрэмжит уртын дууны улсын анхдугаар уралдаан

“Шилдэг уртын дуучин” цом, Монгол Улсын тэргүүний уран сайханч цол

2006 он – Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн Хүндэт медаль

2007 он – Ардын урлагийн алдартан цол, тэмдэг

2009 он – Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан цол

2010 он – Сайн ноён хан аймгийн уртын дууны уралдаан, Мөнгөн медаль

2010 он – МУГЖ С.Сумъяагийн нэрэмжит уралдаан, Тэргүүн байр

2011 он – Нийгмийн ардчилал МЭХ-ны Хүндэт тэмдэг

2012 он – Төрийн дээд шагнал “Алтангадас” одон

2015 он – “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч” цол

2018 он – World Cultural Festival (Мотас), Шагнал

2018 он – Өвөрхангай аймгийн Шилдэг өвлөн уламжлагч

2019 он – Азийн орнуудын ардын урлагийн наадам-ын шагнал

2019 он – Төрийн шагнал “Тусгаар тогтнолын одон”

2020 он – Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одон”

2022 он – World Cultural Festival (Мотас), Хүндэтгэл

2024 он – “Нүүдэлчин” дэлхийн соёлын наадам, Соёлын сайдын шагнал

2024 он – Монголын Уртын Дууны Холбооны 20 жилийн ойн наадмын Шагнал

2024 он – “Монгол угсаатан хэл хуур” тоглолт, Өргөмжлөл

2025 он – “Нүүдэлчин–2025” дэлхийн соёлын наадам

Хоолойн лимбэ төрлөөр “Шилдэг өвлөн уламжлагч”

2025 он – World Cultural Festival (Motac), Appreciation Award

Олон улсын арга хэмжээнд зориулсан товч танилцуулга:

Тэрээр Монголын биет бус соёлын өвийн “Язгуур урлагийн төрөл”-ийг цогцоор нь өвлөн уламжилж, соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, түгээн дэлгэрүүлэлтэд бодит хувь нэмэр оруулсан, олон улсын соёлын наадмуудад эх орноо төлөөлөн амжилттай оролцож буй шилдэг өвлөн уламжлагч юм.



УРГИЙН ОВОГ:

ОВОГ: НАНЗАДЫН

НЭР: ЛАНТУУ

НАС: 88

ХҮЙС: ЭМЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: ДОРНОГОВЬ, САЙХАНДУЛААН

Нанзадын Лантуу нь 1938 онд Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутаг “Алагийн уул” хэмээх газар Гомбодашийн ууган охин болон төрсөн. 1950 онд аймгийн 10 жилийн сургуулийн 4-р ангийг төгссөн. Тэрээр Сайхандулаан сумандаа эцэг, эхийн хамт мал маллахын зэрэгцээ сумын Улаанбуланд байнга оролцон гоцлол дуулж, мандолин тоглон, бүжиглэж байв. 1959 онд аймгийн Соёлын ордонд гоцлол дуучнаар орж, хөгжмийн багш Ч.Банзрагч, Цэенбадам нараар хөгжим, нот заалгаж, ёочин хөгжим тоглож сурсан нь түүнийг хөгжимчин, дуучин, жүжигчний замналд оруулсан юм.

1966 онд Улсын мэргэжлийн шалгалтад бие даан шалгуулж 1-р зэргийн жүжигчин цол хүртсэн. 1980 онд 45 хоногийн мэргэжил дээшлүүлэх дамжаанд суралцаж, хөгжимчин, жүжигчнээр ажилласан. 1988 онд тэтгэврийн насанд хүрсэн ч уран бүтээлийн ажлаа үргэлжлүүлэн нийт Соёлын ордон, театрт 39 жил ажилласан байна.

Уран бүтээлийн амжилт: Монгол ардын болон зохиолчдын 50 гаруй дууг гоцлон, хоршил, цөөхүүл, хамтлагаар 200 гаруй дуу дуулсан. Ёочин, ятга, ксилофон зэрэг хөгжмөөр 50 шахам дан хөгжмийн бүтээл тоглосон. Дуучдын дуу, бүжгийн хөгжим, дан хөгжмийн бүтээл нийлсэн 600 гаруй бүтээлээр Соёлын ордон, театрын тоглолтуудад оролцсон.

Жүжгийн дүрүүд:

Ш.Цэрэн “Анхны жил” – Гажид

Ц.Жагдал “Нарнаас урьдхан” – Урнаа

Д.Намдаг “Шинэ байшинд” – Мятагмаа

Х.Цэвэлээ, Сониндумаа – Дарьхүү, Дэлгэрмаа, Зант

Дожоодорж “Мастерийн төрсөн өдөр” – Жавзан, Аюуш

Мөн Дуламсүрэн зэрэг 49 жүжгийн 58 дүрд тоглож, тухайн үеийн хошин шогийн хөтөлбөр, жижиг үзэгдлүүдэд идэвхтэй оролцож байв.

Зохиож, найруулсан уран бүтээл: Ёочингийн гоцлол:

“Ширээ нуурын долгио”, “Зогдор сугсрах жонжоо”, “Салхин зөөлөн сэвшээ”

Ч.Ойдовын “Алиа Тогмид” хүүхэлдэйн жүжгийн чимэглэл хөгжим – 4, Бүжгийн хөгжим – 9 (МУУГЗ Л.Ухнаа “Барилгачин залуус”, Батмужаан “Хөдөөгийн үзэсгэлэн” гэх мэт) Дуу, хөгжмийн бүтээл: Нийтийн дуу- 59, Уртын дуу-2, Үг, аяыг хамтад нь бичсэн-6, Дууны шүлэг бичсэн-15, Нийт 80 дуу зохиосон: Тухайлбал: “Үйлчин бүсгүй”, “Тал нутгийн эзэн бүсгүй”, “Ноён хутагт Данзанравжаа”, “Талын уянга”, “Барилгачин”, “Аргагүй амраг”, “Зэрэглээ”, “Монгол бүсгүй”, “Янзган зээрд” зэрэг бүтээлүүд орно. “Бүрдэнэ хайрханы залбирал” дууны шүлгийг бичиж, МХЗЭ-ийн шагналт Б.Мөнгөн-Өлзий хөгжмийг нь зохиож, Х.Баярсайханы зохиомж, зураглалаар клип бүтээн олны хүртээл болгосон. Мөн Монгол ардын дуу, дөрвөн хоолойт найрал, бүжгийн хөгжим, үлгэрийн жүжгийн чимэглэл зэрэг олон бүтээлд найруулга хийж, тайзнаа амжилттай тоглуулсан.

Ээж Гомбодашийн зааж өгсөн уламжлалт гар урлалын аргууд болох зүү ороох, шазаргана (хос зүү ороолт), эсгий ширмэл, утас дээс хийх, томох, утсан сүлжээс, Монгол үндэсний зангилаануудыг урлан хийж, сонирхсон хэн бүхэнд зааж сургадаг. Мөн гууль, хулсаар хийдэг аман хуурыг дууриан хулсаар урлаж, “Уулган шарын тэшээ”, “Ингэ ботго нийлэх”, “Хурдан морины хатираа”, “Бухын урамдалт” зэрэг татлагуудыг тоглодог.

1959 оноос цуглуулсан 1000 шахам ардын дуунаас зөвхөн нутгийн ардын 63 дуутай Товь нутгийн түрлэг” дууны ном, 2007 онд Орон нутагт голчлон уншигддаг болон Хутагтын зохиосон аялгуут маани 16 уран бүтээлчдийн болон Бурханы сэдэвтэй дуу 17, бүгд 33 бүтээлтэй “Буяны буман цацраг” ном 2011 онд, Монгол ардын харилцаа 46 дуутай, М.А.Харилцаа дууны ном 2019 онд, “Буяны буман цацраг” номыг дахин шинэчлэн 2020 онд тус тус хэвлүүлсэн.

Дорноговь аймгийн хэмжээнд анх удаа Соёлын биет бус өвийн наадмыг амжилттай зохион байгуулж, аймгийн 14 сумын өвлөн уламжлагчдыг тодруулан, ай сав бүрээс шилдгүүдийг шалгаруулсан. Тус наадамд Н.Лантуу нь өөрийн шавь нарын хамт амжилттай оролцож, “Дорноговь аймгийн Шилдэг 10 өвлөн уламжлагч”, “Монгол” наадмын “Хамгийн өндөр настай шилдэг өвлөн уламжлагч” цолоор тус тус шалгарсан.

Ая зохиосон дуунууд (59) “Хаврын говь”, “Үйлчин бүсгүй”, “Тал нутгийн эзэн бүсгүй”, “Хаврын шинж”, “Хонгор галуу ганга”, “Тахилгат хайрхан”, “Ээж минь та үнэн”, “Ижий нутаг хоёр”, “Шархан хээр морь мину”, “Чандмань хайрхан”, “Ноён хутагт Данзанравжаа” (айзам уртын дуу), “Сүүн хайр”, “Янзган зээрд” (бэсрэг уртын дуу) зэрэг нийт 59 дуу зохиосон. “Ээж минь та үнэн” – Үлэмжийн чанарт наадамд тусгай байр, “Шархан хээр морь мину” – Үлэмжийн чанарт I байр, “Сүүн хайр” – Үлэмжийн чанарт II байр тус тус хүртсэн. Дууны шүлэг бичсэн бүтээлүүд (15) “Үрдээ мөнх аав”, “Ижий тандаа мөргөмүй”, “Нутгийн цэнхэр аялгуу”, “Сулинхээрийн намар”, “Бүрдэнэ

хайрханы залбирал”, “Алтан зул” (улсын уралдаанд тусгай байр), “Өлгийн хийдийн магтаал дуу”, “Ятгахан чи минь”, “Хөдөөгийн сайхан айл”, “Өнөрчүүдийн бүл” зэрэг нийт 15 дууны шүлэг бичсэн.



УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ТӨМӨРХҮҮ

НЭР: БАТМӨНХ

НАС: 80

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ:ГОВЬАЛТАЙ, ШАРГА

Төмөрхүү овогтой Батмөнх нь 1946 онд Говь-Алтай аймгийн Шарга суманд төрсөн. Эдүгээ Улаанбаатар хотод амьдарч байна. Тэрээр 1966 оноос хойш үндэсний сурын спорт, Монгол нум сумны уламжлал, боловсрол, соёлын салбарт 55 гаруй жил тасралтгүй ажиллаж, үндэсний өв соёлыг хадгалан хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан нэрт зүтгэлтэн юм. Т.Батмөнх нь Архангай аймгийн Багшийн сургууль, УБДС-ийн Түүх, газарзүйн ангийг төгсөж, ЗХУ-ын Воронежкийн их сургуульд мэргэжил дээшлүүлсэн. 1975–1995 онд УБДС-ийн Газарзүйн тэнхимд 22 жил багшилж, 5000 гаруй багш, оюутныг сурган хүмүүжүүлсэн. Тэрээр 1966 оноос үндэсний сурын харваагаар хичээллэж, 1976 оноос Монгол нум, сум урлах эрдэмд шамдан суралцаж, 1996 онд Монголын үндэсний нум, сумны анхны үйлдвэр “Эрийн гурван наадам” ХХК-ийг байгуулан, 50 гаруй жилийн турш нум, сум урлан түгээн дэлгэрүүлж байна. Энэ хугацаанд 5000 гаруй харваачийг эвэр нумтай болгож, 20 гаруй шавьд нум урлах эрдмийг өвлүүлсэн.

Т.Батмөнх нь Монголын үндэсний сурын харвааг хөгжүүлэх чиглэлээр: 2002 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Үндэсний сурын харвааг хөгжүүлэх тухай” зарлиг гарахад судалгаа, үндэслэл боловсруулан чухал хувь нэмэр оруулсан. Монголын үндэсний сурын холбооны тэргүүлэгч, дэд тэргүүнээр ажиллаж, холбооны бааз, талбайг бэхжүүлсэн 21 аймаг, олон суманд сурын баг, талбай байгуулж, багш дасгалжуулагч бэлтгэсэн. Улсын мэргэн, спортын мастер, дэд мастер 70 гаруй харваачийг төрүүлсэн “ХҮННҮ НУМ”-ыг сэргээн бүтээж олон улсад Монгол нум сумыг сурталчилсан Түүний урласан нум, сумыг АНУ, Герман, Япон, Солонгос, Франц, Унгар, Их Британи, ОХУ зэрэг 30 гаруй оронд хэрэглэж байна. Мөн дотоод, гадаадын 10 гаруй уран сайхны болон баримтат кинонд нум сум урлан, зөвлөхөөр ажилласан.

Т.Батмөнх нь: Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт, ОХУ-ын Буриад улсын Биеийн тамир, соёлын гавьяат ажилтан Үндэсний сурын спортын мастер, Хүндэт мэргэн бөгөөд эдүгээ ч сурын спортоор идэвхтэй хичээллэн, хүүхэд залуучууд, ахмадуудад сур харвааг зааж, үндэсний өв соёлыг өвлүүлсээр байна. Тэрээр Монголын үндэсний сурын харвааг төрийн бодлогын түвшинд хамгаалж хөгжүүлэх чиглэлээр судалгаа, үндэслэл боловсруулж,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны “Үндэсний сурын харвааг хөгжүүлэх тухай” зарлиг гаргахад чухал хувь нэмэр оруулсан бөгөөд “Үндэсний их баяр наадмын тухай хууль”-д холбогдох өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд мэргэжлийн туршлагаараа оролцсон байна. Мөн УБИС, Үндэсний биеийн тамирын дээд сургуулиудад “Үндэсний сур харвааны үүсэл, хөгжил”, “Сур харвах арга техник” хичээлийг санаачлан сургалтын хөтөлбөрт оруулж, олон зуун багш, дасгалжуулагчийг бэлтгэхэд бодит хувь нэмэр оруулжээ. Т.Батмөнх нь Хүннү, Чингис хааны үеийн нум сумны археологийн олдвор, түүхэн сурвалжид тулгуурлан судалгаа хийж, 2016 онд эртний Хүннү нумны хэв загвар, технологийг сэргээн “Хүннү нум”-ыг шинээр бүтээж олны хүртээл болгосон нь Монгол нум сумны уламжлалыг шинжлэх ухааны үндэслэлтэй сэргээсэн онцлох бүтээл болсон юм. Түүнчлэн аймаг, сум бүрт үндэсний сурын баг, сургалтын бааз бий болгох зорилгоор 1990-ээд оноос хойш Монгол Улсын 21 аймаг, олон зуун сумдад биечлэн ажиллаж, нум сум, сурын талбай, багш дасгалжуулагчийн тогтолцоог бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан байна. Тэрээр үндэсний сурын холбоонд удирдах албан тушаал хашиж, сурын талбайн зураг төсөл, шинэчлэлийг санаачлан хэрэгжүүлж, өнөөгийн Үндэсний сурын харвааны талбай байгуулагдахад бодитой хувь нэмэр оруулсан бөгөөд хүүхэд, залуучуудыг спортоор дамжуулан хүмүүжүүлэх зорилгоор сургууль, дүүрэг, орон нутагт үнэ төлбөргүй сургалтыг олон жил тогтмол зохион байгуулж, 70 гаруй улсын мэргэн, спортын мастер, дэд мастер цолтой харваачдыг төрүүлэн гаргасан билээ.

Т.Батмөнх нь Монголын уран сайхны болон гадаадын кино бүтээлүүдэд нум сум урлан, зөвлөхөөр ажиллаж, Монгол нум сумны өв соёлыг олон улсад сурталчилсан төдийгүй АНУ, Европ, Ази тивийн 30 гаруй оронд Монгол нум, сур харвааг таниулж, Буриад улсад үндэсний нум сумны сургалтыг системтэйгээр хэрэгжүүлсний үр дүнд тус улсын үндэсний харвааг сэргээн хөгжүүлсэн гавьяатай юм. Энэхүү ажлын үр дүнг үнэлж түүнийг 2006 онд ОХУ-ын Буриад улсын Биеийн тамир, соёлын гавьяат ажилтан цолоор шагнасан болно.

Өдгөө Т.Батмөнх нь өндөр насандаа ч үндэсний сурын спортын хөгжилд идэвхтэй оролцож, клуб, багийн дасгалжуулагчаар ажиллан, орон нутаг болон нийслэлийн ахмад, хүүхэд, залуучуудад сур харвааг зааж сурган, үндэсний өв соёлоо амьд хэлбэрээр өвлүүлэн уламжлуулж буй “Батмөнх багш” хэмээн олон нийтэд хүндлэгдсэн нэрт зүтгэлтэн билээ.



УРГИЙН ОВОГ: ӨРЛҮҮД

ОВОГ: ГҮЕНГИЙН

НЭР: БАЛДАНЦЭРЭН

НАС: 79

ХҮЙС: ЭРЭГТЭЙ.

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, БАЯНГОЛ ДҮҮРЭГ

Өрлүүд овогтой Гүенгийн Балданцэрэнгийн товч танилцуулга

Өрлүүд овогтой Гүенгийн Балданцэрэн 1947 онд Булган аймгийн Хангал сумын Улаантолгой хэмээх газар төрсөн.

Бага, дунд ангиа төгсөөд 1968 оноос Булган аймгийн Соёлын ордонд бүжигчнээр ажиллаж, урлагийн гараагаа эхэлсэн бөгөөд 2007 онд тэтгэвэрт гартлаа Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр, Улаанбаатар хотын “Түмэн эх” чуулгад бүжигчин, хөгжимчнөөр ажилласан, өдгөө ч уран бүтээлээ туурвиж буй ахмад уран бүтээлч юм. Тэрбээр Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж буй зүтгэлтэн юм.

#### 1. “Суухан хуур” хөгжмийг сэргээн дэлгэрүүлсэн нь

Г.Балданцэрэн 1984 онд мартагдсан дуу хөгжим сурвалжлан судлах ажлын хүрээнд Булган аймгийн Тэшиг сумын харьяат буриад настан Норжмаа гэдэг хүнээс буриад зон 20-р зууны эхэн үе хүртэл хэрэглэж байгаад мартагдсан “Суухан хуур” хэмээх үхрийн давсган цартай, ганц чавхдаст хөгжмийн зэмсгийг олж илрүүлсэн.

Уг хөгжмийг хувилан хийж, концертын тайзнаа тоглосон нь хөгжмийн мэргэжилтэн, судлаачдаас өндөр үнэлгээ авч, цааш түгээн дэлгэрүүлж, хэрэглээнд дахин оруулах үүрэг хүлээсэн байна. Энэ хугацаанд “Суухан хуур”-ыг 100 гаруй ширхэгээр хийж, олон шавь нартаа заан сургаснаар өнөөгийн байдлаар Булган аймгийн театр, “Түмэн эх” чуулга, Үндэсний урлагийн их театр, буриад зон олноор амьдардаг аймаг, сумд, мөн ОХУ-ын Буриад улсын “Байгаль театр”-ын хөгжимчдийн дунд өргөн дэлгэрчээ.

2026 онд ОХУ-ын Улаан-Үд хотод болох “Алтаргана” наадмын хүрээнд “Суухан хуур”-ын төрлөөр уралдаан, тэмцээн зохион байгуулагдахаар шийдвэрлэгдсэн нь уг хөгжмийн түгэн дэлгэрсний тод илрэл юм. Мөн Г.Балданцэрэн нь 1993 онд Монголын үндэсний телевизийн найруулагч Хишигт болон бусад уран бүтээлчидтэй хамтран “Буриадын суухан хуур” нэртэй кино концерт бүтээсэн нь МҮОНТ-ийн Үндэсний сан хөмрөгт хадгалагдаж байна. Түүнчлэн Хэнтий аймгийн “Хан Хэнтий” чуулгад хоёр

жилийн хугацаанд урилгаар ажиллаж, тус хөгжмийг заан сургаж, тоглолтын урын санг баяжуулсан юм. Өдгөө “Суухан хуур” нь Дорнод, Хэнтий, Булган, Хөвсгөл аймгийн театр, чуулгууд болон буриад зон олноор амьдардаг бүхий л нутагт эгшиглэж байна.

“Нуман хуур” нь ганц чавхдаст цохиур хөгжмийн зэмсэг юм. Энэхүү хөгжмийг 2009 онд олж илрүүлэн, “Эгшиглэн” компанитай хамтран хувиран хийж, Монголын радио, телевизээр сурталчилан танилцуулснаар театр, чуулгууд болон ардын авьяастнуудын дунд түгэн дэлгэрсээр байна.

Монгол үндэсний урлаг, тэр дундаа ардын дуу хөгжмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 167 дуутай ардын дууны түүврийг нотын хамт 2006 онд хэвлүүлэн олны хүртээл болгосон нь урлагийн сургуулийн оюутнууд болон дуунд дуртай уншигчдын дунд эрэлт ихтэй ном болсон билээ. 2001 он-Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Монгол Улсын Гавьяат жүжигчин Ц.Нанжидын нэрэмжит Ардын язгуур урлагийн наадамд “Суухан хуур”, “Нуман хуур”-ын төрөлд тэргүүн байр эзэлсэн. 2024 он-Булган аймагт болсон “Алтаргана” наадмын бэлтгэл ажлын хүрээнд Тэшиг сумын ардын авьяастнуудтай хамтран ажиллаж, “Суухан хуур” заан сургаснаар дэд байр эзэлсэн.



УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ХОНГОР

НЭР: УРТНАСАН

НАС: 70

ХҮЙС: ЭМЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, БАЯНГОЛ ДҮҮРЭГ

Монгол Улсын Соёлын Тэргүүний Ажилтан, Ардын авьяастан, Монгол үндэсний дээл хувцас урлаач Хонгорын Уртнасан 1956 оны 9 дүгээр сарын 10-нд төрсөн. 1986 онд Ховдын Багшийн Дээд Сургуулийг түүх–газарзүйн багш мэргэжлээр төгссөн. Тэрбээр 1974 оноос эхлэн Бүх ард түмний урлагийн их наадамд оролцож, ардын богино дуугаар алтан медаль хүртсэн бөгөөд энэ үеэс монгол болон олон угсаатны уламжлалт дээл хувцсыг судалж, урлан бүтээж эхэлсэн. 40 гаруй жилийн хугацаанд Баруун Монголын, ялангуяа Ойрад, Урианхай угсаатны язгуур хувцас, эд хэрэглэлийг судлан, жинхэнэ эх сурвалжид тулгуурласан бүтээлүүдийг туурвиж ирсэн өвлөн уламжлагч, уран бүтээлч юм.

Цол, шагнал:

1974 он – Бүх ард түмний урлагийн их наадмын алтан медаль

1987 он – Ажилчны урлагийн үзлэгийн мөнгөн медаль

1996 он – Улсын тэргүүний уран сайханч

2009 он – Ардын авьяастан

2012 он – Монгол Улсын Соёлын Тэргүүний Ажилтан, “Алтан гадас” одон

2010 он – Чингэлтэй дүүргийн хүндэт иргэн

2018 он – Монгол Улсын 3-р зэргийн хатгамалчин

2022 он – Баянгол дүүргийн “Нүүдэлчин монгол”, “Сайхан монгол хувцас”, “Бахархалт монгол хувцас” тэргүүн шагнал

Уран бүтээлийн цар хүрээ: Өдгөө түүний цуглуулгад: Урианхай эрэгтэй, эмэгтэй иж бүрэн хос хувцас – 25 багц, Захчин иж бүрэн хувцас – 4 багц, Өөлд, Торгууд, Мянгад, Хотон, Буриад, Төв халх, Цаатан, Дархад зэрэг олон угсаатны 100 орчим дээл хувцас багтдаг. Эдгээр бүтээлүүд нь дээл, ууж, малгай, гутал, бүс, мөнгөн гоёл, хэт хутга зэрэг иж бүрдэлтэй бөгөөд Монгол уран хатгамалын 27 төрлийг шингээсэн, дахин давтагдашгүй ур хийцтэй юм.

Сүүлийн жилүүдэд Улсын баяр наадам, “Дээлтэй монгол”, Цагаан сар, Ардын язгуур урлагийн наадам зэрэг олон нийтийн арга хэмжээнд тогтмол оролцож, дээл хувцасны үзэсгэлэн, үзүүлбэр, лекц уншиж ирсэн. Мөн уран сайхны болон баримтат кино, телевизийн нэвтрүүлэг, дуучдын клипэнд өөрийн урласан хувцсаа оролцуулж, Монгол хувцасаа сурталчилж ирсэн.

2012 он – Олон улсын Туульчдын симпозиумд Баруун Монголын үндэсний хувцасны үзүүлбэр толилуулж, өндөр үнэлгээ авсан.ОХУ, БНХАУ зэрэг оронд 50 гаруй удаа Монгол үндэсний хувцсыг сурталчилсан.

Өвлүүлэн уламжлуулах үйл ажиллагаа: Х.Уртнасан нь: Орон нутагт болон нийслэлд олон арван хүнд дээл оёх арга барил зааж,Урианхай, Тува эмэгтэйчүүдэд уламжлалт хувцас урлах сургалт явуулж,10 гаруй оёдолчин, оёдлын газарт өөрийн ур чадварыг өвлүүлэн сургаж байна.Түүний баримталдаг гол зарчим бол: Зөв эсгүүр, зөв хатгамал, мөнгөн эдлэл, чанартай материал, бат бөх оёдол ингэж урласан дээл нь 100 жилийн настай өв соёлын бүтээл болдог хэмээн үздэг.

Х.Уртнасангийн урлах арга барил:

- ✓ Дээл хувцсыг зөв эсгүүр, зохих хэмжээ, зохион байгуулалтаар урладаг.
- ✓ Хатгамал, мөнгөн эдлэл, гоёл чимэглэлд нарийн ур, уламжлалт арга барилыг шингээдэг.
- ✓ Материалыг чанартай, эртний уламжлалд нийцсэнээр сонгож, бат бөх оёдол хийдэг.
- ✓ Дээл хувцсыг иж бүрэн бүрдэлтэй, малгай, гутал, бүс зэрэгтэй нийлүүлэн урладаг.
- ✓ Өвийг хадгалж, шинэ залуу оёдолчдод заан, сургаж, уламжлалын ухааныг өвлүүлдэг. Х.Уртнасан нь Монголын олон угсаатны дээл хувцас, уран хатгамал, мөнгөн эдлэлийн уламжлалыг судалж, урлан бүтээж, сурталчилж, өвлүүлэн үлдээж буй гурав дахь үеийн өв уламжлагч бөгөөд түүний бүтээлүүд Монголын биет бус соёлын өвд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: БААСАНХҮҮ

НЭР: ЦЭРЭНДАГВА

НАС: 36

ХҮЙС: ЭРЭГТЭЙ



ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, БАЯНГОЛ

Баасанхүүгийн Цэрэндагва нь 1990 оны 2 дугаар сарын 5-нд Төв аймгийн Зуунмод суманд төрсөн. Тэрбээр уртын дуучин, урлаг судлаач, үндэсний бөхийн улсын засуул, улсын бөх цоллогч, улсын морь цоллооч бөгөөд Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан.

Боловсрол: 2006–2009: Соёлын дээд сургуулийн Мэргэжлийн боловсролын сургууль, уртын дуучин мэргэжил, 2010–2014: Соёл урлагийн их сургууль (СУИС), гоцлон дуулаач (Бакалавр) 2020–2022: СУИС, урлаг судлаач (Магистр)

Ажлын туршлага:

2014 оноос Монголын үндэсний бөхийн холбооны жаяг дэгийн багийн гишүүн

2016–2017: Налайх дүүргийн Соёлын ордонд Соёлын менежер

2018–2022: Монголын уртын дууны холбооны Удирдах зөвлөлийн гишүүн

2021 оноос Монголын уртын дууны холбооны Гүйцэтгэх захирал

Улсын морь цоллооч, улсын засуул, улсын бөх цоллогч, Төв аймгийн Хүндэт тэмдэг (2024) Баянгол дүүргийн “Хүмүүнлэг гэр бүл” (2024), Соёлын тэргүүний ажилтан (Монгол Улсын Засгийн газар, 2025) “Тонж манлай 21” сургалтын гарын авлагыг боловсруулан хэвлүүлж, соёлын биет бус өвийн уламжлалыг түгээн дэлгэрүүлдэг.

Б.Цэрэндагва нь Монголын соёл, урлаг, үндэсний спортын өвийг хамгаалах, сурталчлах чиглэлээр онцгой хувь нэмэр оруулж буй нэртэй уран бүтээлч, өвлөн уламжлагч билээ. Уртын дуу, ардын дуу, ерөөл магтаал, морины цол дуу, бөхийн цол дуу зэрэг олон бүтээл туурвиж, 2008–2011 онд “Хууртай мөнхрөх аялгуу”, “Уяхан замбуу тивийн наран” зэрэг уралдаанд тэргүүн байр, Гранпри шагналууд хүртсэн. “Хонгор жаахан Дүүриймаа”, “Сэтгэлийн үг” зэрэг уран бүтээлийн тоглолтуудыг орон нутгаар амжилттай хийсэн. ОХУ-ын Москва, БНХАУ-ын Нанжин, Шанхай хотуудын олон улсын наадамд уртын дуугаараа амжилттай оролцсон.

Шавь бэлтгэл: Өөрийн удирдлага дор олон шавь бэлтгэгдэж, тэднээс “Улсын засуул”, “Улсын дэд засуул”, “Улсын морь цоллооч” нар төрөн гарсан.

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ЗАДИЙН

НЭР: ЦЭНГЭЛСАЙХАН

НАС: 70

ХҮЙС: ЭМЭГТЭЙ



ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

Задийн Цэнгэлсайхан нь 1956 онд Баянхонгор аймгийн Баянцагаан суманд төрсөн. Хүүхдийн болон чих, хамар, хоолойн эмч мэргэжилтэй, Анагаах ухааны болон Төрийн удирдлагын магистр зэрэгтэй, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, уран хатгамалч хүн юм.

Тэр 2005 онд санаачлан байгуулсан Монголын Үндэсний Уламжлалт Уран Хатгамалчдын холбоо (НҮТББ)-ны гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Түүний хүн ардыг соён гэгээрүүлэх, Монгол үндэсний соёлын биет болон биет бус өвийг сэргээн хөгжүүлэх чиглэлээр 36 жил ажилласан туршлага нь төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаатай уялдан, сайн дурын үндсэн дээр хэрэгжиж иржээ.

Үндсэн үйл ажиллагаа, амжилт: Уламжлалт уран хатгамал, зээгт наамал, зоос ширээний сүлжмэлийн урлалын соёлын биет бус өвийг судлах, сурталчлах, өвлүүлэхэд амьдралынхаа 80%-ийг зориулсан. 1987 оноос хойш: Зүү ороох болон загасан нуруу хатгах хатгамал, уламжлалт аргаар хөөрөгний даалин урлах урлалыг 18,000 гаруй хүнд зааж сургажээ. Зоос ширээний сүлжмэлийн урлалыг 200 гаруй, зээгт наамлыг 20 гаруй хүнд биечлэн зааж сургасан. Монгол орон даяар холбооны салбарууд болон сургалтын төвүүдийг байгуулан өвлүүлэн сургах ажлыг эрчимтэй явуулж байна. 2005, 2010, 2018, 2023 онд Уран хатгамалчдын Улсын 4 удаагийн уралдаан зохион байгуулж, 2023 онд “Хайр хүндэтгэлийн урлал” сэдэвт үндэсний анхдугаар чуулганыг Төрийн ордонд зохион байгуулсан. “Уран хатгамал”, “Уран хатгамлын гайхамшиг”, “Урлах эрдмээс суралцаарай”, “Хатгамаллах урлагийн гайхамшиг” зэрэг гарын авлага, номыг 2005 оноос хойш 6 удаа хэвлүүлэн олны хүртээл болгожээ.

Соёлын өвийг олон нийтэд таниулах үйл ажиллагаа: Хатгамалтай эдлэлийн хэрэглээ, гадаад дотоод зах зээлд борлуулалтыг өргөжүүлэн, 40 гаруй орчин үеийн загварыг зохион бүтээж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. 12 төрлийн шинэ арга технологийг зохион бүтээж, зохиогчийн эрхээр баталгаажуулан сургалтандаа хэрэглэн ЮНЕСКО-гийн хүн төрөлхтний биет бус соёлын өвийн төлөөллийн жагсаалтад бүртгүүлэх санаачилгыг 2010 онд гаргаж, холбогдох баримт материалыг

боловсруулан, БСШУЯ-ны сайдын баталгаагаар ЮНЕСКО-д хүргүүлсэн. Монгол уран хатгамлын үзэсгэлэн, сургалт, уралдаан, олон улсын наадмуудад оролцож, Монгол соёлын өвийг дэлхийд сурталчилсан (Их наадам 1991, 2011, Энэтхэг, Унгар, БНСУ, Япон, АНУ, БНХАУ, Грек). Дарханд анх эхлүүлсэн “Цагаан сар” үзэсгэлэн худалдаа, “Гар урлалын брэнд бүтээгдэхүүн” үзэсгэлэн, “Монгол хувцсаараа гоёцгооё” арга хэмжээг тогтмолжуулж, улс орон даяар дэлгэрүүлсэн.

Хүүхэд, залууст өвлүүлэх ажил:

2019 онд Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төв-д уламжлалт уран хатгамлын ангийг шинээр нээж, иж бүрэн тохижуулан сургалт явуулж байна. Охин С.Ганцэцэгээр багшлуулан 2 жилийн хугацаанд 400 гаруй хүүхдэд зааж, зарим сурагчид олон улсын уралдаанд амжилт гаргасан.

Онцлох бүтээл: “Миний эх орон мөнхөд мандан бадраг” цуврал бүтээлүүд: Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа, төрийн бэлгэдлийн цомог, Чингис хааны хөрөг, “Төрийн сүлдний цомог”, “Төрийн далбаа”, “Хүннү костюм” зэрэг бүтээлүүд. Монгол Улс-Сингапурын дипломатын харилцааны 50 жилийн ойд зориулсан шуудангийн маркны бүтээл (“Аяганы уут”) шалгаран хэвлэгдсэн. 3.Цэнгэлсайхан нь Монгол үндэсний уламжлалт уран хатгамлын гайхамшигт соёлын өвийг сэргээн хөгжүүлж, өвлүүлэх, олон нийтэд таниулах, дэлхийд сурталчлахад онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагч юм.

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ №16

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ЛХАГВАСҮРЭН

НЭР: ЛХАМРАГЧАА

НАС: 45

ХҮЙС: ЭРЭГТЭЙ



### ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ:

Увс аймаг, Улаангом хотод төрсөн. 1989–1998 онд Увс аймгийн 1-р 10 жилийн сургуульд суралцсан. 1998–2002 онд Чингис хааны нэрэмжит "Их Засаг" их сургуульд эрх зүйч, хуульч мэргэжлээр төгссөн.

Ажлын туршлага: 2005 оноос ардын язгуур урлагийн "Алтай Хайрхан" хамтлагт хөгжимчин, дуучин, хөөмийчнөөр ажиллаж, Европын холбооны улсуудад (Франц, Итали, Испани, Бельги, Голланд, Герман, Швейцарь) болон БНХАУ, Япон, Оросын Холбооны Улсуудад аялан тоглолт хийсэн. 2007–2016 онд Монгол Улсын Үндэсний Урлагийн Их Театрт гоцлол хөөмийч, магтаалчаар ажиллаж, төрийн болон гадаад дотоодын айлчлалын тоглолтонд оролцсон. 2014–2019 онд МУ-ын урлагийн сургуульд хөөмий, магтаал, товшуурын багшаар ажилласан. 2019 оноос чөлөөт уран бүтээлчээр ажиллаж байна. 2014 оноос хойш монгол хөөмий, язгуур соёлыг өвлөн уламлуулах чиглэлээр 150 гаруй шавь бэлтгэж сургасан. 2019 онд СИТИ их сургуулийн Урлагийн сургуульд урлаг судлалаар магистр хамгаалсан.

### Шагнал, өргөмжлөл:

2013 он – Монгол Улсын Засгийн газрын шагнал “Соёлын тэргүүний ажилтан”

2016 он – Дэлхийн хөөмийн холбооны “Шилдэг гоцлол хөөмийч”

2016 он – Увс аймгийн “Хүндэт тэмдэг”

2017 он – МЗХолбооны “Тэргүүний залуу багш”

2021 он – Төрийн дээд одон “Алтан гадас”

2023 он – Увс аймгийн “Хүндэт иргэн”

2024 он – Архангай аймгийн Өлзийт 100 жилийн ойн тэмдэг

2025 он – Монголын урлагийн ажилтны холбооны “Алтан од”

### Олон улсын амжилт:

2008 он – Улсын ерөөлч, магтаалчдын 6-р уралдааны дэд байр

2009 он – “Монгол хөөмий симпоузм” ОУ-ын хөөмийн уралдааны тэргүүн байр (Хар Сүлд хамтлаг)

2017 он – ОХУ-ын Якут улсад зохион байгуулагдсан олон улсын туульчдын уралдааны шагналт байр

2025 он – Узбекистанд зохион байгуулагдсан БАХШИ олон улсын туульчдын уралдааны гуравдугаар байр

2025 он – Азийн ардын урлагийн их наадмын тэргүүн байр

Уран бүтээлүүд:

Гол бүтээлүүд: “Дэлхийд гайхагдсан монгол урлаг”, “Үлэмжийн чанар”, “Монголын их хатад”, “Хөөмийн эгшигтэй эх орон”, “Нарны домог”, “Нүүдэлчдийн аялгуу”, “Сүнжидмаа”, “Учиртай гурван толгой”, “Салхины дууль”, “Оройн дээд” зэрэг дуулалт, бүжгэн жүжигт оролцсон.

Ая зохиосон болон хөөмийлсэн бүтээлүүд: 2007–2025 онд Тэс голын магтаал, Ардын аман зохиолын олон бүтээлүүдийн ая, хөөмий

Гаргасан цомгууд: 2008 он – “Бие даасан цомог”, 2020 он – “Бие даасан цомог”, 2013–2016 онд Увс аймаг, Улаанбаатар хот болон бусад аймагт олон тоглолт хийсэн. 2019–2024 онд “Дуун тамгатай хүлгүүд”, “Монголоороо”, “ХөгҮмэй” тоглолтод оролцсон.

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ДУРМАН

НЭР: БАЛГАН

НАС: 66

ХҮЙС: ЭРЭГТЭЙ



ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

МУСТА, Монгол Улсын батламжит өв уламжлагч, бий биелээч, онц тээвэрчин, 13 дахь үеийн соёлын биет бус өв уламжлагч Хотон ястан Шаавай овогт Дурмагийн Балган нь Хотон ястны уламжлалт бий биелгээг аав, ээж, авга, нагацаасаа сурч эхэлсэн цагаасаа өнөөг хүртэл өвлөн уламжлуулж, өөрийн үр хүүхдүүдэд өвлүүлэхээс гадна Монгол Улсын өнцөг булан бүрт түгээн дэлгэрүүлэх үйлсийг амжилттай хэрэгжүүлж байгаа Монгол Улсын шилдэг өв уламжлагч юм.

Монгол Улсын Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулдаг олон арга хэмжээнд өөрөө болон үр хүүхдүүдтэйгээ хамт оролцдог. Д.Балган нь Хотон биелгээний өөрийн гэсэн уламжлалт дэг сургалтыг үүсгэхдээ хадам аав Х.Түвдэнгийн бий биелгээнд биед нөлөөлөх нөлөө, мэдрэмжийг өөртөө бүрэн шингээх арга барилыг өвлөн авч, бусад ястнуудын биелгээтэй харьцуулан судалж, үргэлж шинийг эрэлхийлэн хөгжүүлдэг. Түүний энэхүү зан чанар нь үр хүүхдүүдэд нь бүрэн шингэсэн байдаг. 2009 онд ЮНЕСКО-оос Монголын уламжлалт бүжиг бий биелгээг “Яаралтай хамгаалах соёлын биет бус өв”-ийн дэлхийн жагсаалтад бүртгүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан бөгөөд Монгол Улсын шилдэг өв уламжлагчдын улсын жагсаалтад бүртгэгдсэн. 1960 оны 07 сарын 29 Увс аймаг, Тариалан суманд төрсөн. 1969–1976 онд Увс аймгийн Улаангом сумын 1-р арван жилийн сургуульд суралцсан. 1976–1978 онд Өвөрхангай аймгийн Улсын аж ахуйн ТМС-ыг гүний өрөмдлөгийн мэргэжлээр төгссөн. Авто агрегат засварчин, Хотон ястанын бий биелгээ, икэл хуурын татлага (аав, авга, нагац нараас сурсан, 13 дахь үеийн өв уламжлагч) Гэр бүлийн байдал: Эхнэр, 6 хүүхэд, 6 ач, 11 зээ, 1983 онд Хольдог овогт Түвдэнгийн Сэтэнтэй гэр бүл болж, 6 хүүхдийн аав болсон. Өдгөө ач, зээ нийлээд 28-уулаа амьдарч, өвөг дээдсээс өвлөсөн бий биелгээ, икэл хуурын татлагаа үе дамжин өвлүүлж байна. 1984 онд авто тээврийн байгууллагын 50 жилийн ойн урлагийн үзлэгт ардын язгуур урлагийн бий биелгээгээр оролцож хүрэл медаль хүртсэнээс хойш одоо хүртэл улсын болон олон улсын тэмцээнд амжилттай оролцсоор байна. 1999 оноос гэр бүлийн “АЯС” хамтлагийг үүсгэж, үр хүүхдүүддээ Хотон угсаатны бий биелгээ, иклийн татлагыг зааж сургасан нь тэдний хөгжлийн

эхлэл болсон. Гэр бүлээс нь 4 нь Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, 1 нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны жуух бичигтэн, 3 нь тэргүүний ардын авьяастан болсон нь Д.Балганы гэр бүлийн амжилтын оргил хэсэг юм. Түүний том хүү Б.Чулуунбаатар нь Увс аймгийн хүүхдүүдэд үлгэрлэн зааж байна. Хүү Б.Гүрбазар, Б.Ганзориг, Б.Золжаргал нар “Алтай” хамтлагт ажиллаж, эртний нүүдэлчдийн өв соёлыг сурталчилж, Монголд болон олон улсад түгээж байна. Охин Б.Бүзмаа, Б.Цэнгэл нар өөрийн хүүхдүүддээ бий биелгээг зааж, зээ нар нь сургуулиуд, цэцэрлэгүүдэд танилцуулж байна.

42 жил Хотон угсаатны бий биелгээг түгээн дэлгэрүүлж, 2,500 гаруй шавьтай. Хотон биелгээний уламжлалт дэг сургалтыг үүсгэн, бусад угсаатны биелгээтэй харьцуулан судалдаг.2023 онд “Үл тасрах өв” гарын авлагыг бүтээж олон нийтэд түгээн дэлгэрүүлж эхэлсэн.Францын бүжиг судлаач доктор Рафаел Бланчер судалгаандаа Д.Балганы гэр бүлийг суурь болгон ашиглаж, олон улсын хэмжээнд хамтран ажилласан.

2009 онд ЮНЕСКО-д Монголын уламжлалт бүжгийг бүртгүүлэхэд хувь нэмэр оруулсан. Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор үндэсний жагсаалтад бүртгэгдсэн. Хотон биелгээний сургалтын гарын авлагыг бичсэн анхны өвлөн уламжлагч.

УРГИЙН ОВОГ: ДУУТ

ОВОГ: ДЭНДЭВ

НЭР: БАЯРХУЯГ

НАС: 55

ХҮЙС: ЭРЭГТЭЙ



ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, СҮХБААТАР ДҮҮРЭГ

Дуут овгийн Дэндэвийн Баярхуяг нь 1971 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотын Хоёрдугаар амаржих газарт төрсөн. 1989 онд нийслэлийн 37 дугаар дунд сургуулийг төгсөж, 1990–1992 онд Монгол Улсын хилийн цэрэгт хугацаат цэргийн алба хаасан. Цэргийн албаа нэр төртэй хаасны дараа Барилгын техник мэргэжлийн сургуулийг мастерийн зэрэгтэй төгссөн. Тэрээр өвөг эцгээсээ уламжлагдан ирсэн дарханы ур ухаан, гар урлалын мэдлэг, уламжлалт технологийг өвлөн эзэмшиж, 1981 оноос эхлэн Монголын ард түмний соёл иргэншил, түүх дурсгалын үнэ цэнийг илэрхийлсэн соёлын биет болон биет бус өвийн бүтээлүүдийг урлан бүтээж, олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулж ирсэн туршлагатай уран дархан, соёлын өвийг өвлөн уламжлагч юм. 1992 онд Монгол Улсын тусгаар тогтнол, төрт ёсны бэлгэдэл болсон Төрийн 9 хөлт цагаан тугны жанжин оройг урлах ажилд гар бие оролцож, мөн Нийслэлийн Засаг даргын өрөөний тугын догийг хийж гүйцэтгэсэн нь түүний уран чадвар, ур хийцийн өндөр түвшинг илтгэсэн чухал бүтээлүүдийн нэг болж, уран бүтээлийн замналынх нь бодит эхлэл болсон. Тэрээр үндэсний өв соёлыг хадгалан хамгаалах, амьд хэлбэрээр түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Дуут” урлан ХХК-ийг үүсгэн байгуулж, өнөөг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Дуут урлангийн бүтээлүүдэд Монгол шатар, домбо, гүнгэрваа, цацлын халбага, идээний цар, айрагны хувин, халбага сэрээ зэрэг ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнүүд багтах бөгөөд эдгээр нь уламжлалт гоо зүй, түүх, соёлын утга агуулгыг шингээсэн, дахин давтагдашгүй уран хийцтэй, практик хэрэглээтэйгээрээ онцлог юм.

Мөн тэрээр модон сийлбэр, эсгий урлал, арьсан урлалыг хослуулан уламжлалт загвар, хэлбэрийг орчин үеийн хэрэглээнд нийцүүлэн сайжруулж, тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн, байгальд ээлтэй технологийг ашиглан бүтээл урлаж байна. Бүтээгдэхүүнүүддээ зэс, гууль, мөнгө зэрэг эрүүл мэндэд тустай үнэт металлыг ашигладаг бөгөөд эдгээр нь хүний биеийн энергийн тэнцвэрийг дэмжих, эрдэс бодисын дутагдлаас сэргийлэх, зарим сөрөг нөлөөг бууруулах давуу талтай. Д.Баярхуяг нь Монгол шатрын гарал үүсэл, түүхэн хөгжил, бэлгэдэл, үнэ цэнийг судлан, 37 гаруй нэр төрлийн үндэсний шатрын загварыг урлаж, Монголын

шатрын холбоо, Дэлхийн шатрын холбоо, Соёлын яам, эрдэм шинжилгээ, сургалт судалгааны байгууллагууд, шатар судлаачидтай хамтран ажиллаж байна. Нийгмийн хариуцлагын хүрээнд сургууль, цэцэрлэгүүдэд үндэсний хэв загвартай шатаруудыг хямд өртгөөр нийлүүлж, түүх, үлгэр домог, туульсын сэдэвтэй 30 гаруй төрлийн загварыг боловсруулан бэлэн болгосон.

Түүний уран бүтээлүүдийг дотоод, гадаадын 50 орчим үзэсгэлэн, арга хэмжээнд 40 гаруй бүтээлээрээ Монгол Улсаа төлөөлөн дэлгэн үзүүлж, гадаад харилцаа, соёлын хамтын ажиллагааны хүрээнд амжилттай оролцож ирсэн. Тухайлбал, БНХАУ, ОХУ, Франц, Саудын Араб зэрэг улсуудад зохион байгуулагдсан соёлын болон ЖДҮ эрхлэгчдийн үзэсгэлэнгүүдэд оролцсон бөгөөд 2022 онд Саудын Араб улсад өв соёл, бие даасан шатрын үзэсгэлэн гарган хунтайжаас талархлын бэлэг хүртсэн. 2023 онд Франц улсын Нант хотын түүхийн музейд зохион байгуулагдсан “Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнд 20 гаруй бүтээлээр оролцсон нь олон улсын түвшинд Монголын соёлын өвийг сурталчилсан чухал үйл явдал болсон.

Мөн тэрээр телевиз, хэвлэл мэдээллийн олон удаагийн нэвтрүүлэг, соёлын болон уран сайхны кино, түүхэн контентод уран дарханаар оролцож, “Хийморь”, “2000” зэрэг кинонд үндэсний өв, соёлын агуулгыг шингээсэн бүтээлч ажил хийсэн. Түүний хөдөлмөр, бүтээлийг төр, засаг, олон нийтийн зүгээс өндрөөр үнэлж, Сүхбаатар дүүргийн “Хөдөлмөрийн алдар” медаль (2013, 2015), “Үйлдвэрийн тэргүүний ажилтан” тэмдэг (2014), СБД-ийн “Хүндэт тэмдэг”, Улаанбаатар хотын Захирагчийн жуух бичиг (2022), “Соёлын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг (2024), ЮНЕСКО-Бүтээлч хот төслийн “Бүтээлч иргэн” тэргүүн байр (2025) зэрэг нэр хүндтэй шагналуудаар шагнагдсан. Өдгөө Дуут овгийн Д.Баярхуяг нь Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны иргэн, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, “Дуут” урлан ХХК-ийн захирлаар ажиллаж, Монголын үндэсний соёлын өвийг хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсаар байна.

УРГИЙН ОВОГ: ТУГЧИН

ОВОГ: ЭНХТУЯА

НЭР: ХҮРЭЛБААТАР

НАС: 51

ХҮЙС: ЭРЭГТЭЙ



### ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, НАЛАЙХ ДҮҮРЭГ

Говь-Алтай аймгийн Шарга сумын уугуул, Төв аймгийн Баян сумын харьяат, Нийслэлийн Налайх дүүргийн Соёлын ордны уртын дууны багш, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Үндэсний бөхийн улсын ахлах засуул, Улсын бөх цоллогч, улсын морь цоллооч, Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Энхтуяагийн Хүрэлбаатар

Э.Хүрэлбаатар нь соёлын биет бус өвийн эх хэл, аман уламжлал, түүний илэрхийллийн айд хамаарах уртын дуу, үндэсний бөхийн цол, морины цол, гийнгоо марзай, ерөөл магтаал, мөн үндэсний бөхийн засуулын сургалтыг олон жилийн турш тасралтгүй явуулж, олон зуун шавь, өвлөн уламжлагчийг бэлтгэн хүмүүжүүлсэн нэрт уран бүтээлч, багш юм.

Тэрбээр үндэсний урлаг, соёлын өвийг Монгол Улсын хэмжээнд төдийгүй гадаад улс орнуудад сурталчлах үйлсэд идэвх санаачилгатайгаар манлайлан оролцож ирсэн.

Сургалт, өвлөн уламжлуулалтын ажил:

2025 оны байдлаар: Үндэсний бөхийн цолны сургалт – 300 гаруй, Морины цол, гийнгоо марзайн сургалт – 600 гаруй, Ерөөл магтаалын сургалт – 400 гаруй, Уртын дууны сургалт – 1200 гаруй, Сур, суран эдлэлийн сургалт – 20 нийт 2500 гаруй өвлөн уламжлагч, суралцагч нарыг сургалтанд хамруулсан байна.

ШАВЬ НАРЫН АМЖИЛТ: Шавь Б.Цэрэндагва “Тонж манлай II” төслийг хэрэгжүүлж, 4 аймгийн төв, 21 суманд, 20,000 гаруй км зам туулан 1000 гаруй өвлөн уламжлагч, хүүхэд залууст үндэсний бөхийн засуул, бөхийн цол, морины цол, гийнгоо марзайн анхан шатны болон танин мэдэхүйн сургалт амжилттай зохион байгуулсан. Мөн өөрийн хүү Хүрэлбаатарын Өлзийхутаг нь “Гийнгоо их наадам”-д морины цол, гийнгоо марзайн төрлөөр амжилттай оролцсон.

ФЕСТИВАЛЬ, ОЛОН УЛСЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас зохион байгуулдаг “Нүүдэлчин” Дэлхийн соёлын фестивальд шавь нарын хамт дүүрэг, нийслэлээ төлөөлөн удаа дараа амжилттай оролцсон. Нийслэлийн Соёл, урлагийн газартай хамтран БНСУ-ын Гванжу хотын “Дурсамж–2025” соёлын фестивальд Монгол Улс, Улаанбаатар хотыг төлөөлөн оролцож,

үндэсний урлагаа сурталчилсан.Үндэсний их баяр наадамд улсын ахлах засуул, бөх цоллогч, улсын морь цоллоочоор тогтмол ажиллаж байна.

“ТҮМНИЙ ЭХ” УРТЫН ДУУНЫ САЛБАР ХОЛБОО: Э.Хүрэлбаатар нь 2016 онд Налайх дүүрэгт “Түмний эх” уртын дууны салбар холбоог 41 хүний бүрэлдэхүүнтэйгээр үүсгэн байгуулж, тогтвортой үйл ажиллагаа явуулсны үр дүнд Монголын уртын дууны холбооны 2025 оны шилдэг салбар холбоо-оор шалгарсан. Хийж хэрэгжүүлсэн гол ажлуудаас: “Хууртай мөнхрөх аялгуу” уртын дууны уралдааныг 15 дахь жилдээ амжилттай зохион байгуулж байна.“Үл бүдгэрэх их өв” төслийн хүрээнд 1090 уртын дуучны сургалтыг хэрэгжүүлсэн. “Тэнгэр аялгуу” 21 уртын дуутай цомог гаргасан. “Итгэлийн нар” хандивын тоглолтоор нийгмийн хариуцлагын ажил амжилттай зохион байгуулсан. Нүүдэлчин дэлхийн соёлын наадамд Нийслэлийн баг Тэргүүн байр эзэлсэн. Холбооны гишүүд төрийн дээд шагнал, одон медалиар шагнагдсан.



УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ЭРДЭНЭЦОГТ

НЭР: БААТАРЖАВ

НАС: 54

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Эрдэнэцогтын Баатаржав нь Монголын язгуур аман өв болох баатарлаг тууль, хөөмэй, цуур, уламжлалт хөгжмийн зэмсгийн салбарт 37 жилийн турш тасралтгүй, бодит үр дүнтэй ажилласан удам дамжсан өвлөн уламжлагч, судлаач, уран бүтээлч юм. Баатаржав нь Баруун Монголын 30 гаруй бүрэн хэмжээний баатарлаг туулийг уламжлалт амьд хайлалтын хэлбэрээр сэргээн амилуулж, бичлэгжүүлэн хадгалснаар устаж болзошгүй аман өвийг бодитоор аварсан. Мөн Урианхайн хөгжмийн уламжлал, түүний дотор хөөмэй, цуурын 20 гаруй хэв маягийг багш нараас нь аман хэлбэрээр өвлөж, залгамж халаанд дамжуулсан нь өв тасрах эрсдэлийг үлэмж бууруулсан бодит үр дүн юм.

Тэрбээр 120 гаруй жил тасарсан чашга, дудар, эвэр нуман хуур, хулсан хуур зэрэг уламжлалт хөгжмийн зэмсгүүдийг судалгаа, туршилтад тулгуурлан сэргээн амилуулж, хэрэглээний түвшинд буцаан оруулсан. Үүний хүрээнд 60 цуур, 32 товшуур, 5 икэл, 8 дээл хийлгэн музей, өв тээгчдэд хүлээлгэн өгсөн нь Монголын язгуур хөгжмийн өвийг хадгалж, түгээхэд чухал ач холбогдолтой. Мөн Алтай ятгатай туулийг 1400 орчим жилийн дараа дахин эгшиглүүлсэн нь Монголын хөгжмийн түүхэнд онцгой үйл явдал болсон.

Эрдэнэцогтын Баатаржав нь амьд өвийг эрдэм шинжилгээний түвшинд судлах цогц арга зүй боловсруулж, Монгол туулийн үечлэлийн онолыг шинээр дэвшүүлэн 2022 онд докторын (PhD) зэрэг хамгаалсан. Монгол, Төв Ази, Сибирийн аман өвийг харьцуулсан судалгааг олон улсын түвшинд хийж, 8 ном, 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн нь шинжлэх ухаанд оруулсан томоохон хувь нэмэр юм.

Тэрбээр АНУ, Европ, Ази, Австрали, Африк тивийн нэр хүндтэй 20 гаруй их сургууль, судалгааны байгууллагад уригдан лекц, амьд тоглолт, сургалт явуулж, Монголын язгуур өвийг 5 тивийн 100 гаруй улсад амьд эхээр нь сурталчилсан. Мөн ЮНЕСКО-д бүртгэгдсэн Монголын биет бус соёлын өвүүдийн хүрээнд аман эх сурвалж, хөгжмийн тайлбар, зан үйлийн судалгаа, нотолгоо материал бэлтгэхэд албан ёсоор оролцож, Монголын өвийг олон улсын түвшинд үнэн зөвөөр

бүртгүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Түүний хөдөлмөрийг олон улсад өндрөөр үнэлж, Испанийн “Дэлхийн маэстро” цол, Дэлхийн угсаатны хөгжмийн Гран при, Дэлхийн Ардын Урлагийн Наадмын “Шилдэгийн шилдэг – Гран при”, “Соёлоор танигдсан хүн” зэрэг нэр хүндтэй шагналуудыг олгосон нь 40–60 гаруй орны шилдэг өв тээгчдээс шалгарсан бодит амжилт юм. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Соёлын гавьяат зүтгэлтэн”, Гадаад харилцааны яамнаас “Соёлын элч” цолоор тус тус шагнагдсан.

Үндэсний болон олон улсад оролцсон тэмцээн, наадмын тойм: Э.Баатаржав нь Монголын язгуур аман өв болох тууль, хөөмэй, цуур, уламжлалт хөгжмийн төрлөөр үндэсний болон олон улсын хэмжээний нэр хүндтэй тэмцээн, наадам, фестивалиудад тогтмол оролцож, өндөр амжилт үзүүлсэн.

### **Олон улсын тэмцээн, наадам**

- Дэлхийн угсаатны хөгжмийн олон улсын наадмуудад оролцож Гран при, Тэргүүн шагналууд хүртсэн
- Дэлхийн Ардын Урлагийн Наадам (30-р наадам) – “Шилдэгийн шилдэг – Гран при”
- Дэлхийн хөөмийн олон улсын тэмцээн, холбооны наадам – “Оны шилдэг хөөмийч”
- Доминикан улсад зохион байгуулагдсан Дэлхийн эртний хөгжмийн наадам – Гран при, “Соёлоор танигдсан хүн” шагнал
- Унгар улсын “Дунай Карнавал” олон улсын наадам – Тэргүүн Гран при
- Киргизстан улсад зохион байгуулагдсан олон улсын туульсын наадам (“Бахши”) – Шүүгчийн шагнал
- Европ, Ази, Америк, Африк тивийн олон улсын язгуур урлаг, этно хөгжмийн фестивалиудад оролцож тэргүүн болон шилдэг шагналууд хүртсэн

### **Үндэсний хэмжээний тэмцээн, наадам**

- Монгол Улсад зохион байгуулагдсан тууль, хөөмэй, язгуур урлагийн улсын чанартай наадам, симпозиум, уралдаануудад амжилттай оролцсон
- Дэлхийн нүүдэлчдийн наадамд Монгол Улсаа төлөөлөн оролцож шилдэг өвлөн уламжлагчийн шагнал хүртсэн.
- Үндэсний хэмжээний язгуур урлагийн уралдаан, наадмуудаас олон удаа шилдэг байр, шагнал авсан Эдгээр тэмцээн, наадамд оролцсон амжилтууд нь Э.Баатаржавыг 40–60 гаруй орны шилдэг өв тээгч, уран бүтээлчидтэй өрсөлдөн шалгарсан, Монголын язгуур аман өвийг олон улсын түвшинд үнэлүүлсэн бодит нотолгоо юм.

Баатаржав нь Монголын Алтайн урианхайн язгуур туульчдын Хоо–Живэртийн удмын тахилч туульчдын уламжлалыг дөрөв, таван үе дамжин өвлөсөн жинхэнэ өв тээгч юм. Тэрбээр тууль хайлахын өмнө “Нашир” хэмээх тахилгын зан үйл үйлддэг уламжлалыг бүрэн хадгалж, аман уламжлалын ёс зүй, хэл найруулга, дэг жаягийг

алдагдуулахгүйгээр өнөөг хүртэл уламжилж ирсэн. Баруун Монголын туульч, хөөмийч, цуурчдын багш–шавийн аман уламжлалаар өвлөсөн мэдлэг нь Монголын аман өвийн тасралтгүй залгамж чанарыг бодитоор баталгаажуулж байна.

Тэрбээр 120 гаруй жил тасарсан чашга, дудар, эвэр нуман хуур, хулсан хуур зэрэг уламжлалт хөгжмийн зэмсгүүдийг судалгаа, туршилтад тулгуурлан сэргээж, хэрэглээнд буцаан оруулсан. Мөн 1400 гаруй жилийн дараа Алтай ятгатай туулийг дахин эгшиглүүлж, Монголын язгуур хөгжмийн түүхэнд онцгой ач холбогдол бүхий бодит үр дүнг бүтээсэн.

Хэвлэн гаргасан бүтээл: Тэрбээр 30 гаруй жилийн хугацаанд тууль, язгуур хөгжим, хөөмөйтэй холбоотой 13 нэрийн ном хэвлүүлсэн бөгөөд эдгээр нь Монголын аман өв, язгуур хөгжмийн судалгаанд чухал эх сурвалж болж байна. Улсын хэмжээнд болон гадаадад олон зуун сургалт, лекц, дадлага явуулж, 1300 гаруй жангарч хүүхэд, олон арван шавь бэлтгэсэн, 60 цуур, 32 товшуур, 5 икэл, 8 дээл хийлгэн музей, өв тээгчдэд хүлээлгэн өгсөн, 2024 оноос “Монгол цуур” цахим сургалтыг амжилттай хэрэгжүүлж байна. Эдгээр нь өвийг нэг хүний хэмжээнд бус, тогтолцоотойгоор өвлүүлэх залгамж халааг бүрдүүлсэн бодит үр дүн юм. Олон нийтийн болон мэргэжлийн хүлээн зөвшөөрөл: Түүний хөдөлмөрийг дотоод, гадаадын мэргэжлийн байгууллагууд өндөрөөр үнэлж:

- 2011 – “Дэлхийн маэстро” (Испани)
- 2011 – Дэлхийн угсаатны хөгжмийн Гран при
- 2016 – Дэлхийн Ардын Урлагийн Наадмын “Шилдэгийн шилдэг – Гран при”
- 2019 – Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн
- 2019 – Гадаад харилцааны яамны Соёлын элч
- 2022 – Доктор (PhD) зэрэг олон улсын болон төрийн өндөр шагнал хүртээжээ.

Олон улсын сурталчилгаа, ЮНЕСКО-ийн түвшний оролцоо: Тэрбээр АНУ, Европ, Ази, Австрали, Африк зэрэг 5 тивийн 100 гаруй улсад Монголын язгуур өвийг амьд эхээр нь сурталчилж, Харвард, Стэнфорд, Кембриж, Беркли зэрэг дэлхийн нэр хүндтэй их сургуулиудад лекц, тоглолт хийсэн.

Мөн ЮНЕСКО-д бүртгэгдсэн Монголын биет бус соёлын өвүүдийн нотолгоо, аман эх сурвалж, зан үйлийн тайлбар бэлтгэхэд албан ёсоор оролцсон.

УРГИЙН ОВОГ: БЭЙС

ОВОГ: АЛТАНГЭРЭЛ

НЭР: ДАГЗМАА

НАС: 75

ХҮЙС: ЭМЭГТЭЙ



ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

Бэйс овогтой Алтангэрэлийн Дагзмаа нь 1951 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр мэндэлсэн, Хөвсгөл аймгийн уугуул, одоо Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 6 дугаар хороонд оршин суудаг ахмад уран бүтээлч, соёлын биет бус өвийн нэрт өвлөн уламжлагч юм. Тэрээр 12 наснаасаа эхлэн өвөг дээдэс, эцэг эх, ахмад уран бүтээлчдээсээ уламжлалт халх сурын уухай, сур харваа, уртын дуу, ерөөл магтаал, хэл хуур, домын үлгэр зэрэг нүүдэлчдийн соёлын биет бус өвийг өвлөн сурч, өнөөг хүртэл 60 гаруй жилийн турш тасралтгүй судалж, хөгжүүлж, түгээн дэлгэрүүлж ирсэн дөрөв дэх үеийн шилдэг өвлөн уламжлагч юм. А. Дагзмаа нь Мөрөн хотын 10 жилийн сургууль, Анагаах ухааны сургууль, Намын дээд сургуулийг дүүргэж, Монгол Улсын эрүүл мэндийн салбарт 37 жил үр бүтээлтэй ажилласан туршлагатай. Үүний зэрэгцээ 1962 оноос хойш үндэсний сурын харваа, язгуур урлагийн чиглэлээр идэвхтэй уран бүтээл туурвиж, улсын баяр наадмын сур харваанд 47 удаа, язгуур урлагийн наадамд тасралтгүй оролцож иржээ.

Тэрээр халх сурын уламжлалт урилга, оноо, самбарын гурван төрлийн уухайг судлан баримтжуулж, 2010 онд Шадар ван Чингүнжавын мэндэлсний 300 жилийн ойд зориулан уухайн цомог бүтээж, 450 хувь хэвлүүлэн сургалтын зорилгоор үнэ төлбөргүй түгээсэн нь соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмэр болсон юм. Мөн Хотгойдын найрын дуу “Өндөр сайхан бор” дууг анх удаа улсын тайзнаа дуулж олны хүртээл болгосон.

А. Дагзмаа нь 2001 онд “Хөвсгөл сурын харваа” холбоог үүсгэн байгуулж, 300 гаруй шавь бэлтгэн сурын уухай, сур харвааны уламжлалыг өвлүүлсэн бөгөөд шавь нараас нь улсын тод харваач, спортын мастер, аймгийн цолтнууд олноор төрөн гарсан байна.

Тэрээр АНУ, Бразил, Япон, БНСУ, Хятад, Унгар, Мексик, Сингапур, ОХУ-ын Буриад, Төвд зэрэг 11 улсад өөрийн хувийн зардлаар эх орон, соёлын өвөө сурталчилж, олон улсын наадам, чуулган, уралдаанд амжилттай оролцсон. 2019 онд БНСУ-д зохион байгуулагдсан “Дэлхийн бүтээлч эмэгтэйчүүдийн чуулган”-д сурын

уухайгаар оролцож олон улсын инновацын бүтээлээр мөнгөн медаль хүртсэн нь түүний уран бүтээлийн олон улсын үнэлгээ болсон юм.

А. Дагзмаа нь Монгол Улсын Соёлын яамны харьяа Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын биет бус өвийн улсын нэгдсэн бүртгэлд сурын уухай өвийн төрлөөр бүртгэгдсэн бөгөөд “Нүүдэлчин наадам”, “Мазаалай фестиваль” зэрэг арга хэмжээнд 2018–2025 онуудад тогтмол оролцож, 3000 гаруй иргэн, гадаадын жуулчдад нүүдэлчин ахуй, ёс заншил, өв соёлыг таниулан сурталчилсан байна.

Түүний хөдөлмөр зүтгэлийг үнэлж:

- Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
- Аймгийн мэргэн
- Халх сурын болон волейболын спортын мастер
- Соёлын тэргүүний ажилтан
- Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан
- Алдарт эхийн II одон

зэрэг төр, салбарын олон шагнал, цол хүртсэн. 1978–2025 онуудад нийт 47 удаагийн Үндэсний баяр наадмын сур харваанд оролцсон (Үндэсний хэмжээнд) 1981 – ОХУ-ын Буриад улс, Монгол Улсын хилийн уулзалт соёлын арга хэмжээ (Олон улсын) 1996 – Монгол Улсын Анхдугаар язгуур урлагийн наадмын шилдэгүүдийн тоглолтод сурын харваа, уухайн үзүүлбэрээр оролцсон (Үндэсний) 1996 оноос – Язгуур урлагийн наадмуудад хэл хуур хөгжмөөр тасралтгүй оролцож эхэлсэн (Үндэсний) 1999 – Жалханз хутагт Дамдинбазарын зохиол “Өндөр сайхан бор” уртын дууг анх удаа дуулж олны хүртээл болгосон (Үндэсний) 2001 – “Хөвсгөл сурын холбоо” ТББ байгуулж, сурын харвааг сурталчилсан, 2010 – Халх сурын 3 төрлийн уухай бүтээлээр бие даасан “Цомог” гаргаж, Монгол Улсын оюуны өмчид бүртгүүлсэн. 2012 – БНХАУ-ын Төвдийн олон улсын харваачдын уралдаанд оролцсон (Олон улсын) 2015 – Бразилийн Палмас хотын “Нутгийн уугуул иргэдийн наадам”-д оролцсон (Олон улсын) 2016 – БНХАУ-ын Нангино мужийн Дэлхийн олон улсын сур харваан наадамд оролцсон. 2016 – Япон, Токио хотын шефийн холбооны арга хэмжээнд үндэсний сур харваа, уухай, уртын дуугаар оролцсон 2017 – ОХУ-ын Буриад улсын сур харвааны арга хэмжээнд сурын уухайгаар оролцсон 2018 – ӨМӨЗО-ны Баруун Үзэмчин барга хошууны сур харвааны арга хэмжээнд оролцсон 2018 – “Нүүдэлчин Монгол” наадамд сурын уухай, сур харваа, уламжлалт ёс заншлаар оролцсон 2019 – БНСАУ-д зохион байгуулагдсан Дэлхийн бүтээлч эмэгтэйчүүдийн чуулганд сурын уухайгаар оролцож, дэлхийн инновацын төрөлд мөнгөн медаль хүртсэн (Олон улсын) 2019 – “Нүүдэлчин Монгол” наадамд оролцсон 2022 – “Нүүдэлчин Монгол” наадамд оролцсон 2023 – “Нүүдэлчин”

дэлхийн соёлын фестивальд уламжлалт баяр наадам, уриа дуудлагаар оролцсон  
2024 – “Монгол угсаатны хэл хуурчдын холбооны анхдугаар чуулган, уралдаанд”  
оролцсон 2025 – “Нүүдэлчин Монгол” наадам, “Нүүдэлчин” дэлхийн соёлын  
фестивальд сурын уухай, сур харваа, уламжлалт ёс заншил, цагаан сар тэмдэглэх  
ёс, дом шившлэгээр оролцсон.

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: НАЦАГ

НЭР: ДАМДИНДОРЖ

НАС: 59

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: ХОВД АЙМАГ, ДУУТ СУМ



Нацаг овогтой Дамдиндорж нь 1967 оны 12 дугаар сарын 01-нд Ховд аймгийн Дуут сумын Босго хэмээх газар малчин Баатар овогтой Нацагийн отгон хүү болон төрсөн. Тэрээр бага наснаасаа Урианхайн алдарт туульч Заны Жилкэр, түүний охин Норолмаа зэрэг нэрт туульчдын дэргэд өсөж, тууль, цуур, товшуур хөгжмийн язгуур уламжлалыг шимтэн сурч өвлөсөн юм.

1976–1984 онд Дуут сумын 8 жилийн сургуульд суралцаж, 1990 онд Улаанбаатар хотын Багшийн бэлтгэх сургуулийг бага ангийн багш мэргэжлээр төгссөн. Улмаар төрсөн нутагтаа багшаар ажиллахын зэрэгцээ 1992 оноос Урианхай тууль, цуур, товшуур хөгжмийн сургалтыг тогтмол зааж эхэлсэн.

1992 онд “Дуут нуур” язгуур урлагийн хамтлагийг байгуулж, тууль, цуур, товшуур хөгжмөөр сум, аймаг, бүс, улсын чанартай тэмцээн уралдаанд амжилттай оролцон хамтлаг болон ганцаарчилсан төрлөөр 300 гаруй медаль, шагнал хүртсэн. Боловсролын байгууллагад ажиллах хугацаандаа Монгол тууль, цуур, товшуур хөгжмийн сургалтын туршилтын хөтөлбөр хэрэгжүүлж, дотоодын 750 гаруй шавь бэлтгэсэн нь түүний өвлөн уламжлуулах үйлсийн бодит үр дүн юм.

Тэрээр НӨУЁБ-тай хамтран Төрийн тахилгат хайрхан болон орон нутгийн овоо тахилгын ёслолд тууль хайлж оролцон, байгаль дэлхийгээ аргадах зан үйлийг түгээн дэлгэрүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулж ирсэн. Мөн урианхай түмний тууль, цуур, магтаал, хошин яриа зэрэг язгуур урлагийг хойч үедээ өвлүүлэн үлдээх үйлсэд тасралтгүй зүтгэж байна.

Н.Дамдиндорж нь Монголын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан ардын язгуур урлаг, тууль, цуурын наадмуудаас алт, мөнгө, хүрэл медаль, тусгай шагналууд хүртэж, 2013 онд “Төв Азийн тууль” олон улсын их наадмаас “Төрийн титэмт туульч”, 2015 онд Монгол Улсын Төрийн соёрхолт туульч Б.Авирмэдийн нэрэмжит “Монгол тууль” улсын анхдугаар наадмаас Тэргүүн байр эзэлж, энэ цагийн тэргүүн туульч гэдгээ нотолсон.

Тэрээр “Хүннүгийн модон цуур”, “Алтайн эзний дуудлага” зэрэг баримтат кино, “Уулс туульсын орон” олон улсын уран бүтээлд оролцож, Монгол тууль, цуурын урлагийг дотоод, гадаадад сурталчлан таниулахад бодитой хувь нэмэр оруулсан. Мөн Монгол тууль, цуурын урлагийг ЮНЕСКО-д бүртгүүлэх үйлсэд язгуур өвийн талаас нь идэвхтэй оролцож байна.

Өдгөө тэрээр 35 жил боловсролын салбарт үр бүтээлтэй ажиллаж, 2025 оны байдлаар 15 гаруй хүүхдэд тууль, цуур, товшуур хөгжмийн сургалт явуулж, Алтайн Урианхайн соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулж буй Монгол Улсын нэр хүндтэй, шилдэг өвлөн уламжлагч юм.

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ЛУВСАНДАМДИН

НЭР: ЦЭРЭНДЭЖИД

НАС: 75

ХҮЙС: ЭМЭГТЭЙ



ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: ТӨВ АЙМАГ, АЛТАНБУЛАГ СУМ,

Бараа судлаач, уламжлалт гар урлаач Л.Цэрэндэжид нь 1968 онд 8-р анги төгсөж, Худалдааны техникумын бараа судлалын ангид суралцан 1970 онд төгссөн. 1971 оноос Төв аймгийн Алтанбулаг сумын Худалдаа бэлтгэлийн ангид тасралтгүй 30 гаруй жил ажиллаж, тэтгэвэрт гарсан. Хөдөлмөрийн хугацаандаа салбартаа тэргүүлж, “Системийн аварга”, “100 давсан хувьтан”, “Худалдааны тэргүүний ажилтан” зэрэг хүндэт цол, шагнал хүртсэн.

Л.Цэрэндэжид нь гяраг бүс нэхэх, сүлжих уламжлалт гар урлалын өвийг хадам эцэг Лувсаннамсрайгаас өвлөн эзэмшсэн. Тус урлал нь 1937 оноос улбаатай бөгөөд байгалийн түүхий эд, уламжлалт багаж, арга технологид тулгуурласан онцлогтой.

Тэрбээр энэхүү өвийг 4 үе дамжуулан өвлүүлж, өөрийн үр хүүхэд, ач зээ нар болон:

- ЕБС-ийн сурагчид
- Оюутан, насанд хүрэгчид
- Алтанбулаг, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Дэлгэрхаан, Бүрэн, Эрдэнэсант сумдын иргэд зэрэг нийт 100 гаруй хүнд уламжлалт аргаар гяраг бүс нэхэх ур чадварыг заан сургажээ.

Сүүлийн 35 жилийн хугацаанд:

- 1235 ширхэг гяраг бүс
- 10 асар
- 31 майхан
- 40 гэрийн цагаан бүрээс (дотуур, гадуур)  
зэрэг уламжлалт гар урлалын бүтээгдэхүүнийг урлан, төрийн байгууллага болон иргэдэд захиалгаар нийлүүлсэн.

Мөн орчин үеийн хэрэглээнд нийцүүлэн дээлний бүсийг өнгө, материалын зохистой сонголттойгоор хөгжүүлж, малчид, бөхчүүд, лам нар, урлаг соёлынхон, аялагч жуулчдад зориулан үйлдвэрлэж байна.

## Сурталчилгаа, түгээн дэлгэрүүлсэн байдал

- МҮОНРТ-ийн “Өрхийн үйлдвэрлэл хөдөө орон нутагт” нэвтрүүлэгт (2003, 2007, 2009) – 3 удаа
- Өлзий телевизийн “Төв аймагт – Өрхийн үйлдвэрлэл” нэвтрүүлэгт (2016, 2020) – 2 удаа
- 2025 оны “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцож, МҮОНРТ-ийн “Гарваль” студийн нэвтрүүлгээр уламжлалаа сурталчилсан
- “Төв аймгийн брэнд бүтээгдэхүүн” сэтгүүлд 2018, 2019 онд “Шилдэг бүтээгдэхүүн – Гяраг бүс” нийтлэл хэвлэгдсэн

## Шагнал, урамшуулал (товч)

- “Шилдэг үйлдвэрлэгч” – Алтанбулаг сум (1992)
- “Нэг сум – Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн, Хүрэл медаль (2006)
- “Өрхийн үйлдвэрлэл” үзэсгэлэн, Хүрэл медаль (2011)
- “Намрын налгар өдрүүд” үзэсгэлэн, 3-р байр (2014)
- “Хөдөлмөрч манлай ахмад” тэмдэг (2020)
- “Алтангадас” одон (2022)

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ №24

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: МИЧИР

НЭР: БАТГЭРЭЛ

НАС: 58

ХҮЙС: ЭРЭГТЭЙ



ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: БАЯН-ӨЛГИЙ, БУЯНТ СУМ

Мичирийн Батгэрэл нь 1968 онд Баян-Өлгий аймгийн Буянт суманд төрсөн, урианхай угсааны уламжлалт сурын харваач, ахмад багш, сурын харвааны биет бус соёлын өвийг өвлөн уламжлагч юм. Тэрээр бага наснаасаа эхлэн эцэг эх, ахмад үеийн харваачдаас урианхай сурын харвааны арга ухаан, ёс жаягийг өвлөн сурч, уламжлалт харвааг тасралтгүй эзэмшин хөгжүүлж ирсэн бөгөөд өдгөө 40 гаруй жилийн турш энэхүү өвийг хадгалан хамгаалж, хойч үед уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд тууштай ажиллаж байна.

М.Батгэрэл нь Монголын харваачдын холбоо болон уламжлалт сурын харвааг хөгжүүлэх, хамгаалах, сурталчлах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын идэвхтэй гишүүнээр олон жил ажилласан. Тэрээр Монгол Урианхай сурын Тэргүүлэгчээр ажиллаж байх хугацаандаа урианхай сурын харвааны дүрэм, журмыг боловсронгуй болгох ажлыг санаачлан хэрэгжүүлж, уг уламжлалт өвийг спортын төрөл хэлбэрт шилжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан юм.

Олон улсын хэмжээнд Монголын уламжлалт сурын харвааг сурталчлан таниулах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, 2012 онд Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан уламжлалт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон. Мөн 2013–2014 онд Бүгд Найрамдах Казахстан Улсад морьт харваа болон урианхай сурын харвааг залуу харваачдад сурталчлан таниулах, сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулж, багш, дасгалжуулагчийн үүргийг гүйцэтгэсэн. 2013 онд Нур-Султан хотод урилгаар очиж Казахын үндэсний сур болон “Жанбы ату” харвааг зааж, олон тамирчдыг бэлтгэн гаргасан байна.

Тэрээр шавь нарын хамтаар олон улсын хэмжээний уламжлалт харвааны арга хэмжээнд тогтмол оролцож, багш, сургагчийн хувиар Монголын урианхай сурын харвааны арга барил, ёс заншлыг гадаад орнуудад сурталчлан таниулсаар ирсэн. Казахстан Улсын Атырау хотод зохион байгуулагдсан уламжлалт харвааны олон улсын тэмцээнд шавь нараа удирдан оролцож, амжилттай оролцсон нь үүний нэг жишээ юм.

Мөн 2025 оны 8 дугаар сард Оросын Холбооны Улсын Барнаул хотод зохион байгуулагдсан “Алтай нурууны улс, аймгууд” олон улсын арга хэмжээний хүрээнд урианхай сурын харвааны сургалт, дадлагын үйл ажиллагаанд оролцож, шавь нарын хамтаар уламжлалт нум, сум, чих, эрхийвч, агсуурга зэрэг зэвсэг хэрэгслийг уламжлалт арга технологиор биечлэн урлан хийж, сургалтад ашигласан. Энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан урианхай сурын харвааны зэвсэг, хэрэгслийг уламжлалт аргаар бэлтгэх мэдлэг, ур чадварыг залуу үед өвлүүлж, онол-дадлагыг хослуулсан сургалтыг амжилттай хэрэгжүүлж байна.

М.Батгэрэл нь үндэсний болон урианхай, буриад сурын харваанд өндөр амжилт гаргасан, олон удаагийн улсын болон аймгийн аварга, “Улсын мэргэн”, “Улсын хошой мэргэн”, “Дархан мэргэн”, “Даншиг мэргэн”, “Буриад сурын улсын мэргэн”, “Спортын мастер” цол хүртсэн нэрт харваач юм. Тэрээр Үндэсний их баяр наадмын харваанд үндэсний, урианхай, буриад сурын төрлөөр нийтдээ 5 удаа түрүүлж, олон удаа дэд болон хүрэл байрт шалгарсан байна.

Түүний сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны үр дүнд урианхай сурын харвааны арга барил, ёс жаягийг өвлөсөн олон залуу харваач төрөн гарч, аймаг, улсын цол хүртсэн нь энэхүү биет бус соёлын өвийг хадгалан хамгаалах, залгамж халааг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр болж байна.

Мичирийн Батгэрэл нь Монголын урианхай сурын харвааны түүх, уламжлал, ёс заншлыг амьд өв болгон хадгалж, үндэсний болон олон улсын түвшинд түгээн дэлгэрүүлж буй нэр хүндтэй өвлөн уламжлагч, ахмад харваач юм.

УРГИЙН ОВОГ: ШАВАГУУД

ОВОГ: СҮХБААТАР

НЭР: ЧИНБАТ

НАС: 56

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УВС АЙМАГ, ТҮРГЭН СУМ



Увс аймгийн Түргэн сумын харьяат, Дөрвөд далай ханы их дархан Арсан Хавдарын 7 дахь үеийн ач, уран дархан Шавагууд овогт Сүхбаатарын Чинбат нь 1970 онд төрсөн, эрэгтэй. Тэрбээр 1986 оноос эхлэн эцэг, өвгөдөөсөө зуун зуунаар уламжилж ирсэн Монгол дарханы уламжлалт арга ухаан, ур хийц, дом шившлэгийн мэдлэгийг 6 дахь үеийн дархан Гүнзэний Сүхбаатар эцгээсээ язгуур чанараар нь бүрэн өвлөж, 37 жилийн турш үндэсний гар урлалын салбарт тасралтгүй ажиллан, соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн өв тээгч юм.

С.Чинбат нь Увс аймгийн Улаангом суманд амьдарч, Хөдөлмөрийн дээд сургуулийн Увс салбарыг дүүргэн дээд боловсрол эзэмшсэн. Уран дархан мэргэжилтэйгээс гадна хөдөлмөрийн эдийн засагч, бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй, сэхээтэн уран бүтээлч юм. Тэрбээр 1988–2010 онд Увс аймагт ааваасаа шавь сургалтаар өвлөн сурсан уран дарханы ур чадвараа хөгжүүлж, 2010 оноос хойш Увс аймгийн Улаангом суманд байрлах “Хөх сар” урландаа 8 дахь үеийн дархан, ган сийлбэрч хүү Чинбатын Ган-Очирын хамтаар бүтээлээ туурвиж байна.

Дархан С.Чинбат нь Монгол Улсын Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэлийн 7045 дугаарт бүртгэлтэй “Монгол дарханы уламжлалт арга ухаан” өвийн төрөлд хамаарах өвлөн уламжлагч бөгөөд баруун Монголчууд, ялангуяа Ойрад түмний гоёл чимэглэл, ахуйн эд өлгийн хэлбэр хийц, хээ угалз, дом шившлэгийн утга агуулгыг судлан, уламжлалт хэв маягийг алдагдуулахгүйгээр гар аргаар урлан бүтээдэг онцлогтой. Түүний бүтээлүүд нь Монголчуудын ахуй амьдрал, төр ёс, хийморь сүлд, гал голомтын бэлгэдлийг илэрхийлсэн гүн утга агуулгатай байдаг.

С.Чинбат нь өөрийн хүүгийн хамтаар уламжлалт гар урлалын дараах үндсэн бүтээлийн цувралуудыг туурвиж ирсэн. Үүнд эртний Монголын цэргийн сүр хүч, төрийн бэлгэдлийг илэрхийлсэн хар, цагаан сүлд, гурван хөлт тулга, зэвсэг, морины ган тамга, эмээл хазаар, дөрөө, баавар зэрэг багтсан “Талыг эзэгнэгч” цуврал; мөнгөн болон ган сийлбэрт хэт хутга, эмэгтэй хүний үндэсний мөнгөн гоёл чимэглэл, аяга, бөгж, бугуйвч зэргийг багтаасан “Талын зочин” цуврал; шинэ төрсөн хүүхэд, нас

биед зориулсан сахиус, хамгаалалтын эдлэл, очир, хастай бөгж, мөнгөн бүс зэрэг дом шившлэгийн утга агуулгатай “Дом, шившлэгт бүтээл” цуврал орно.

Тэрбээр Монгол Улсын Засгийн газар, МУГЖ С.Жавхлан нарын хамтарсан “Хамаг Монгол” төслийн хүрээнд “Хар сүлд” бүтээлийг хүүгийн хамтаар урлаж, БНХАУ-ын Өвөр Монгол, Халимаг, Буриад, ОХУ-ын Тува улсад аялуулан дэлхий даяар тархан суусан Монгол угсаатныг урлаг, өв соёлоор нэгтгэхэд бодитой хувь нэмэр оруулсан. Мөн Увс аймгийн 100 жил, Түргэн сумын 100 жил, Төгсбуянт хүрээний 300 жилийн ойн хүрээнд Галдан бошигт хааны галыг сэргээн бадраах тулгатай холбоотой түүхэн бүтээлийг уламжлалт аргаар урлаж, 2025 оны 7 дугаар сарын 24-нд Дэлгэрмөрөний дэнж дээр ёслолыг уламжлалт зан үйлээр гүйцэтгэн зохион байгуулсан нь түүний онцлох гавьяаны нэг юм.

С.Чинбатын болон түүний эцэг, өвгөд, үр ач нарын урласан бүтээлүүд Увс аймгийн музей, Монголын Үндэсний музей, Монголбанкны Эрдэнэсийн сангийн музей, ОХУ-ын Санкт-Петербург хотын Эрмитажийн музей зэрэг дотоод, гадаадын нэр хүндтэй музейн сан хөмрөгт хадгалагдаж, Монгол дарханы хэдэн зууны түүх, өв соёлыг илтгэн харуулж байна. Тэрбээр Увс аймгийн түүхт 100 жилийн ойд зориулан аймгийн музейд “Хөх сар” нэртэй үзэсгэлэн гаргаж, нэгэн удмын 8 үе дамжсан уран дархны бүтээлүүдийг олон нийтэд толилуулсан нь дотоод, гадаадын 6000 гаруй жуулчны сонирхлыг татжээ.

С.Чинбат нь уран бүтээлээ олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор дотоод, гадаадын олон үзэсгэлэн, наадам, чуулганд идэвхтэй оролцож, баруун бүсийн шилдэг бүтээгдэхүүн, гран при, алт, мөнгөн медаль, олон улсын наадмын тэргүүн байр зэрэг олон шагнал хүртсэн. Түүний хөдөлмөр, ур чадварыг үнэлж “Ардын авьяастан” цол, “Алтан гадас” одон, Хөдөлмөрийн хүндэт медаль зэрэг төр, салбарын өндөр шагналуудыг олгосон байна.

Түүнчлэн С.Чинбат нь өвлөн уламжлагчийн хувьд хүүдээ дарханы эрдмийг бүрэн өвлүүлэн, ахмад настнууд, залуучууд, орон нутгийн иргэдэд уламжлалт гар урлалын арга ухааныг зааж сурган, шавь бэлтгэж ирсэн. Ингэснээр Монгол дарханы уламжлалт мэдлэг, ур чадварыг таслахгүй хадгалж, ирээдүй хойч үед бодитоор өвлүүлэн үлдээж буй нь түүний соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд оруулж буй хамгийн чухал гавьяа юм.

## ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧ № 26

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: РАВЖААГИЙН

НЭР: САНЖСҮРЭН

НАС: 73

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, БАЯНГОЛ ДҮҮРЭГ



Р.Санжсүрэн нь 1953 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Увс аймгийн Ховд суманд айлын дөрөв дэх хүүхэд болж төрсөн. 1961 он хүртэл гэрээр хүмүүжиж 1962 оноос Увс аймгийн 1 дүгээр 10 жилд суралцаж 1972 онд ерөнхий боловсролын сургуулиа төгссөн. Сургуулиа төгсөөд Улаанбаатар хотод Багшийн дээдэд найрал дууны багш Удирдаач мэргэжилээр суралцаж төгсөөд Увс аймгийн Драмын театрт багшилаад 2013 онд тэтгэвэртээ гарсан. 1997 оны 09 дүгээр сарын 04-ны өдөр Соёлын тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнагдсан бөгөөд 2010 онд Ойрад монголын “Их хөгсүү” ардын урлаг, соёлын анхдугаар их наадамыг өөрийн биеэр зохион байгуулсан. 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Алтан гадас одонгоор шагнуулсан. 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдөр Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан.

2019 оны 07 дугаар сарын 02-нд Улаангом хотын хүндэт иргэн цол тэмдгээр шагнагдсан. 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Монголын урлагийн ажилтны холбооны Алтан од шагналаар шагнагдсан. 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Монголын ахмадын холбооны “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан. 2022 оноос Увс аймагт үйл ажиллагаа явуулдаг Дөрвөдийн ут дууны холбоо төрийн бус байгууллагатай хамтран Увс аймгийн Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн, Давст, Сагиль, Түргэн, Улаангом Ховд аймгийн Дөргөн сумуудаар явж Дөрвөдийн ут дууны судалгаа хийж 115 дуу бүхий “Зуунаас зуунд өвлөгдсөн төгс аялгуу” судалгааны номыг Увс аймаг байгуулагдсаны 100 жилийн ойд зориулан бүтээж хэвлүүлэв.

2024 онд Увс аймгийн Ховд сумын 100 жилийн ойн соёл урлагийн арга хэмжээний ерөнхий продюсер найруулагчаар ажиллаж баяр наадмын нээлт хаалт болон концертийг бэлтгэн тоглуулав. Санаан байнаа, Елдэн салхи, Миний монгол зэрэг арав гаруй дууны уран бүтээл туурвисан ба Санаан байнаа дуу нь нийтэд түгэн дэлгэрсэн болно. Одоо Баяд ардын ут дууны судалгааны ажлаа эхлүүлж “Зуунаас зуунд өвлөгдсөн төгс аялгуу” номын хоёрдугаар номыг хэвлэлтэнд гаргахаар бэлтгэл ажилдаа явж байна.

УРГИЙН ОВОГ:

ОВОГ: ДАЛХАА

НЭР: ЭРДЭНЭЗУУ

НАС: 61

ХҮЙС: ЭРЭГТЭЙ

ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ: УЛААНБААТАР, БАЯНГОЛ ДҮҮРЭГ



Далхаа овогтой Эрдэнэзуу 2003 оноос өнөөг хүртэл БГД-ийн Үндэсний сурын баг тамирчдыг бүрдүүлж, багийн ахлагч, дасгалжуулагчаар ажиллах хугацаандаа:

БГД-ийн харваачдаас улсын мэргэн 6 төрөн гаржээ Үүнд:

Гавъяаттамирчин Дархан мэргэн Х.Даваажаргал улсад 3 удаа түрүү, 2 удаа айраг

Даян мэргэн Ц. Баасанхүү улсад 1 түрүү

МУ-ын мэргэн Х. Болдбаатар I түрүү, 2 айраг

МУ-ын мэргэн Г.Батзаяа 1 түрүү 1 айраг

Монгол улсын гоц харваач Ч. Одонхүү зэрэг улсын цолтонгууд төрөн гарсан.

ОУ-ын тэмцээнээс А. Батболд, Б.Цээлэйсүрэн, Б. Ганзориг нарын харваачид үнэмлэхүй амжилт гарган Олон улсынхэмжээний Мастер цол хүртсэн.

Шавь нараас Аймгийн мэргэн 70 гаруй, Спортын мастер 200 гаруй, Спортын дэд мастер 50 гаруй, Сумын цолтон 30 гаруй төрөн гарч улсын бүсийн өндөр чансаатай тэмцээнүүдэд амжилт гарган “2024 оны Шилдэг харваач”, “2025 оны Онцлох харваач”,

“Эрхий мэргэн -2025”- ийн талархал хүртсэн харваачид төрөн гарсаар байна. 2012-2016 онуудад Үндэсний сурын холбооны тэргүүлэгчээр ажилласан бөгөөд энэ хугацаанд Хэнтий аймгийн Галшар, Архангай аймгийн Хашаат сум, Ховд аймгийн Манхан сумпуудад сургалт явуулан сурын салбар холбоо байгуулсан.

2015-2016 онд ӨМӨЗОрны Хөлөнбуйр аймагт эвэр нумаар эрхийвчлэн харвах өв соёлыг дэлгүүрэн түгээж, Малжих 4 хошуунд олон шавь бэлдсэн нь Өвөр монголдоо төдийгүй олон улсад өндөр амжилуудыг гагасан.

2017 онд ӨМӨЗОрны Шилийн гол аймагт уригдан очиж МҮСурын болон Өвөр монголын Саранбай харваа болон Үндэсний сурын Хана, Товхоо, Хасаа харвааг эвэр нумаар эрхийвчлэн харвах арга техникийг 50 гаруй харваачид өвүүлэн зааж үлдээсэн. Белги улсад шавь аймгийн мэргэн спортын мастер Б. Уртнасан үндэсний уламжалалт харвааг түгээн дэлгэрүүлэн ажиллаж байна.

2025 онд БНСУ-ын Улсан хотод болсон уламжлалт харвааны ДАШТ д шавь Б. Ганзоригийн хамт явж үнэмлэхүй амжилтаар дэлхийн аварга болсон. Энэ тэмцээнд:

ЗОм ийн зайнд Казакстаны байнд Алтан медаль,

70 м ийн зайнд Туркийн байнд Алтан модаль,

90 м-ийн зайнд Унгарын байнд Шилдэг 8 харваачаар

150 м ийн зайнд БНСУ-н байнд шигшээ 16-т тус тус шалгарч нийлбэр дүнгээр  
Дэлхийн “ГРАНПРИ” аварга болсон амжилт гаргалаа.

Д. Эрдэнзуу миний уламжлалт аргаар хийсэн эвэр нум болон сувинер нумыг  
АНУ, Канад, Франц, Швед зэрэг дэлхийн олон улсад худалдан авдаг юм.



